

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 09 сар | Дугаар 22

ГАРЧИГ

- 2-4 Бодлогын нийтлэл
- 5-7 Зохицуулалтын мэдээ
- 8-9 Шинэ технологи хувьцаа эзэмшигчдийн идэвх, оролцоог нэмэгдүүлнэ
- 9 Давхар бүртгэлийн журамд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар
- 10-11 Инновацийг дэмжих, хөгжүүлэх арга хэрэгслүүд
- 12-15 Судлаачийн индэр
- 16 Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо
- 17-18 Санхүүгийн боловсрол “Хувьцаа гэж юу вэ?”
- 19 Хөрөнгө, оруулагч үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах
- 20 Компанийн засаглалын эрх зүйн орчинг сайжруулах нь
- 21-24 Зах зээлийн мэдээ
- 25 Санхүүгийн зах зээлийн сарын мэдээ
- 26 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976-51-264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📱 @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

ШИНЭ ТЕХНОЛОГИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИДЭВХ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ



Хувьцаат компаниудын засаглал, тайлагналын ил тод байдал болон засаглалыг сайжруулах хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо хэрхэн ажиллаж байгаа талаар Хорооны дэд дарга Т.Цэрэнбадралтай ярилцлаа.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын засаглал, тайлагналын ил тод байдал ямар байгаа талаар ярилцлагаа эхлэх үү?

Хувьцаат компаниуд үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулж, гүйцэтгэлээ үнэн зөв тайлагнах нь зах зээлд урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулах, бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлэх гол нөхцөл болдог. Компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан зэрэг мэдээллээ хагас жил тутам Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд хүргэх үүрэгтэй. 2020 оны II улирлын байдлаар Хөрөнгийн биржид бүртгэлтэй 199 хувьцаат компаниас 156 нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулсан. Хороо болон Хөрөнгийн биржид эдгээрээс хурлын материал, санхүүгийн тайлангаа ирүүлсэн компани 146. Үүнээс биржийн нэгдүгээр ангилалд бүртгэлтэй 18 хувьцаат компанийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт 100 хувь. Харин хоёрдугаар ангиллын 42 хувьцаат компанийн хэрэгжилт 95 хувь, гуравдугаар ангиллын 139 хувьцаат компанийн хэрэгжилт 64 хувьтай байна. Биржийн бүртгэлийн ангилал дээшлэх тусам компанийн засаглал, ил тод байдлын үзүүлэлт сайжирсан. Харин

гуравдугаар ангиллын хувьцаат компаниудад Хороо болон Хөрөнгийн биржийн зүгээс мэдээллийн ил тод байдлыг хангуулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах хүрээнд арга хэмжээ авах шаардлагатай. Энэ дагуу хоёр байгууллагаас хамтарсан ажлын хэсэг байгуулж ойрын хугацаанд тодорхой ажлууд хийхээр бэлтгэж байна.

Төрийн өмчит хувьцаат компаниудын засаглалын үнэлгээг “Компанийн засаглалын хөгжлийн төв”-өөс өнгөрсөн онд хийсэн. Энэ үеэр компаниудын нэгдсэн үнэлгээ 54 хувьтай буюу сул дүнтэй гарсан. Ялангуяа, мэдээллийн ил тод байдлаар хамгийн бага оноо үзүүлсэн. Компаниуд санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллээ олон нийтэд нээлттэй хүргэх хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлдэггүй гэсэн үг. 2020 оны II улирлын байдлаар Хөрөнгийн биржид төрийн өмчит 18, төрийн өмчийн оролцоотой 10 нийт 28 хувьцаат компани бүртгэлтэйгээс 23 нь Хороо болон Хөрөнгийн биржид хувьцаа эзэмшигчдийн хурлын материал, санхүүгийн тайлангаа ирүүлсэн. Иймээс төрийн өмчит компаниудын компанийн засаглалыг сайжруулах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх хэрэгтэй.

Үргэлжлэл 8-р нүүрт >>

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.




БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

МӨНГӨН ХӨРӨНГИЙН БОЛОН НОМИНАЛ ДАНСНЫ ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТЫН ОРЧИН, ЦААШДЫН ХАНДЛАГА:

1. Үнэт цаасны зах зээл дээрх өмчлөх эрхийн бүртгэлд зөвхөн биет хэлбэрээр гаргасан үнэт цаасыг хадгалж, бүртгэх ажиллагааг үздэг байсан бол түүхэн хөгжлийн үе шат, улс орнуудын онцлогоос шалтгаалж хувьсан өөрчлөгдөж, олон төрлийн бүртгэлийн хэлбэр бий болсон. Хөгжиж буй болон хөгжингүй дийлэнх орнуудад үнэт цаасны номинал дансыг ашиглах замаар арилжааны хэлцлийн дараа өмчлөх эрхийн бүртгэл хийснээр зардлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадвараа дээшлүүлдэг. Өмчлөх

эрхийн бүртгэл нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын томоохон үүргийг гүйцэтгэсээр байна.

Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл нь хөгжиж буй болон хөгжингүй үнэт цаасны зах зээлтэй орнуудын хөгжлийн ялгаатай байдлаас хамааран олон төрөл хэлбэртэй боловч нийтлэг 3 хэлбэр болох шууд, шууд бус, холимог хэлбэрийн өмчлөх эрхийн бүртгэл давамгайлдаг бөгөөд улс орнуудад ашиглагддаг хэлбэрийг графикаар үзүүлбэл:



Шууд хэлбэрийн өмчлөх эрхийн бүртгэлийн систем: Энэ нь хамгийн анх үүссэн бүртгэлийн хэлбэр бөгөөд хөрөнгө оруулагч буюу харилцагч үнэт цаас гаргагчтай шууд харилцаж, үнэт цаастай холбоотой эрхээ зөвхөн өөрөө хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг бүртгэлийн хэлбэр юм. Үнэт цаас гаргагч нь өөрийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг хөтөлж, гаргасан хувьцааг шууд эзэмшиж буй этгээд нь эрхээ бодитойгоор хэрэгжүүлж, дундын зуучлагч байгууллагуудын хууль бус үйлдэл, оролцооноос бүрэн хамгаалсан бүртгэлийн тогтолцоо юм.

Шууд бус өмчлөх эрхийн бүртгэлийн систем: Үнэт цаасны зах зээлтэй хөгжиж буй болон хөгжингүй дийлэнх оронд ашигладаг. Хөрөнгө оруулагч нь биет үнэт цаасыг эзэмших шаардлагагүй, төвлөрсөн

хадгаламжийн байгууллага нь үнэт цаасны зуучлагч компанийн харилцагчдын бүртгэлийг түүний нээсэн номинал дансанд хадгалдаг. Өөрөөр хэлбэл, үнэт цаас гаргагч, төвлөрсөн хадгаламжийн байгууллага хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг түүнд үйлчилгээ үзүүлж буй зуучлагч брокерийн дансанд бүртгэж, хадгалах үйлчилгээг үзүүлдэг. Мөн хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нь үнэт цаас гаргагчтай шууд холбогдох шаардлагагүй ба хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийг эцсийн өмчлөгч гэж тодорхойлдог. Үнэт цаасны гүйлгээг зах зээлийн зуучлагчид бүртгэлтэй үнэт цаасны дансаар дамжуулан өмчлөх эрхийг шилжүүлэх, эзэмших эрх нээгддэг бөгөөд уламжлалт шууд бүртгэлийн системийг бодвол цаг хугацаа, өртөг, зардлыг бууруулдагаараа давуу талтай.

Холимог бүртгэлийн систем: Сүүлийн жилүүдэд санхүүгийн шинэ технологийн хөгжил, хөгжиж буй орнууд дахь арилжааны хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор бодит цагийн горимоор олон тооны хэлцлийн өмчлөх эрхийг шилжүүлэх шаардлага бий болсон. Үүнтэй холбоотой дээрх бүртгэлийн системийг түлхүү ашиглаж эхэлсэн. Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын бүртгэлийн харилцааг сайжруулж, зуучлагч байгууллагуудын оролцоог аль болох хязгаарлах шинжийг агуулсан нь элдэв шимтгэл, хураамжийн хэмжээг бууруулахад нөлөөлдөг.

Номинал дансанд хадгалагдаж буй үнэт цаас, мөнгөн хөрөнгийн эцсийн өмчлөгчийн нэр нь үнэт цаас гаргагчийн бүртгэлд харагдахгүй учир эрхийг хамгаалах асуудал зайлшгүй яригддаг. Хөрөнгө оруулагчийн эрх, хамгаалал гэж түүний ирээдүйд хүлээж буй санхүүгийн болон эдийн засгийн үр ашигтай холбоотой бөгөөд компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүдийг томилоход санал өгөх, компани дампуурсан нөхцөлд үлдсэн хөрөнгөөс ашиг хүртэх зэргийг авч үздэг. Дээрх эрхээ хэрэгжүүлэхэд **шууд бус, холимог хэлбэрийн бүртгэлийн системийн хүрээнд номинал данс хөтлөгч мэргэжлийн байгууллага**, үнэт цаас итгэмжлэн удирдагчид эрхээ шилжүүлэх эсэх, шилжүүлсэн нөхцөлд эрхээ хэрхэн хангуулах вэ зэрэг асуудал үүсч, дээрх этгээдүүдийн хооронд бий болох сонирхлын зөрчлийг шийдвэрлэх асуудал зайлшгүй яригддаг.

Номинал дансны бүтэц: Шууд бус хэлбэрийн өмчлөх эрхийн бүртгэлийн болон холимог тогтолцоотой нөхцөлд зайлшгүй номинал дансыг ашиглах шаардлагатай бөгөөд номинал дансны төрлийг энгийн шатлалт, олон шатлалт бүтэцтэй гэж хуваадаг. Энгийн шатлалт бүтэц нь үнэт цаас гаргагч, мэргэжлийн байгууллагын нээсэн номинал дансны хооронд хийгдэх гүйлгээ юм. Данс хөтлөгчид зөвхөн эцсийн өмчлөгч этгээд хэн гэдгийг мэдэх боломжтой. Харин олон шатлалт бүтэц нь энгийн шатлалт бүтцийг дотроо агуулахаас гадна томоохон эцсийн өмчлөгч бүрийн дансыг багтаасан омнибус хэлбэрийн дансны бүтэц юм. Өөрөөр хэлбэл гадны томоохон мэргэжлийн хөрөнгө оруулалтын сангууд тухайн улсад хөрөнгө оруулалт хийхдээ зайлшгүй тусгай данс нээх шаардлагатай гэж үзсэн нөхцөлд дээрх хэлбэрийг хэрэгжүүлдэг. Мөн данс хөтлөгч

оператор дансны хөтлөлтийг сонирхлын зөрчилгүй гүйцэтгэх, бүртгэлийг хөтлөх өндөр түвшний бэк оффиссын програм хангамж шаардлагатай.

Номинал данстай холбоотой нийтлэг асуудлууд, шийдвэрлэх, арга зам: Шууд бус болон холимог хэлбэрийн өмчлөх эрхийн бүртгэлийн тогтолцоотой улс оронд зөвхөн номинал данс хөтлөгч этгээдэд тухайн үнэт цаасны өмчлөгчийн мэдээлэл хадгалагддаг. Иймээс үнэт цаас гаргагчийн хувьд:

- Эцсийн өмчлөгчийг тодорхойлох хэрэгцээ шаардлага:
- Хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах:
- Эцсийн өмчлөгчийн хувийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгардаг.

Номинал данс хөтлөгчид тавигдах шаардлага: Төрийн зохицуулагч байгууллагаас шууд бус болон холимог хэлбэрийн системтэй нөхцөлд үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэл хөтлөгч этгээдүүдэд дараах шаардлагыг тавьдаг. Үүнд:

- Номинал данс хөтлөгч этгээдэд үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох:
- Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн тус бүрийн дансыг хадгалах, найдвартай байдал:
- Харилцагчийн хөрөнгө, номинал данс хөтлөгчийн хөрөнгө тусдаа байх:
- Номинал данс хөтлөгчийн мэдээллийн баазад тавигдах шаардлага:

Төрийн зохицуулагч байгууллагаас номинал данс хөтлөгч этгээдийн хөрөнгөөс харилцагчийн хөрөнгийг тусгаарлах чиглэлд анхаарал хандуулах ёстой. Хэрэв үүнийг хийгээгүй нөхцөлд номинал данс хөтлөгч этгээд дампуурах, төлбөрийн чадваргүй болсон нөхцөлд харилцагчийн хөрөнгө үрэгдэх, шүүхэд өмчлөлийн маргаан бий болох эрсдэл дагуулдаг. Тиймээс төрийн зохицуулагч байгууллагаас өөрийн орны онцлог нөхцөлд тохирсон үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг тогтолцоог бүрдүүлж хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах чиглэлд хяналт шалгалт, зохицуулалтын хэрэгслүүдийг төвлөрүүлэх шаардлагатай юм.

2. Үнэт цаасны зах зээлийн мөнгөн хөрөнгийн гүйлгээний хөгжлийн үе шат:

Манай улсын хувьд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн шатанд хөрөнгийн зах зээлийг өмч хувьчлалын хэрэгсэл байдлаар үүсгэн бий болгосон. Хөрөнгийн биржээр дамжуулан анх 475 улсын үйлдвэрийн газрын хувьцааг цэнхэр тасалбараар иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлж, өмчлөх эрхийг бүртгэх ажиллагааг гүйцэтгэсэн. 1992–1995 оны улсын үйлдвэрийн газрыг хувьчлах анхдагч зах зээлийн арилжаа хийж, үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид харилцагч тус бүрээр данс нээх байдлаар өмчлөх эрхийг баталгаажуулж байсан. Харин үнэт цаасны зах зээлд хоёрдогч зах зээлийн арилжаа 1995 онд эхэлснээс хойших хугацаанд Хөрөнгийн бирж Төлбөр тооцооны алба, 2002 оноос хойших хугацаанд “ҮЦТТХТ” ХХК үнэт цаасны дансыг нээж бүртгэх, үнэт цаасны мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог гүйцэтгэж байсан бөгөөд харилцагчийн хувьцааны болон ногдол ашиг, ногдол хувийн мөнгөн хөрөнгийг бэлнээр брокерийн компаниар дамжуулан тарааж байсан.

Энэ бүхнээс үүдэж компаниудын ёс зүй, сахиалга хариуцлага алдагдаж, түүнийг дагаад харилцагчдын хөрөнгийг хувьдаа завших, мөнгө хүсэх өргөдлийг хуурамчаар үйлдэн өөр харилцагчдын дансанд шилжүүлэх, хувьцааг өөрийн нэр дээр худалдан авах хууль бус үйлдэл ихээр гарах болсон. Иймээс Хорооноос нэр бүхий зарим компаниудын үйл ажиллагааг шалгаж, холбогдох хууль хяналтын байгууллагуудад шилжүүлсэн байдаг.

Санхүүгийн зохицуулах хорооноос “ҮЦТТХТ” ХХК-тай хамтран 2010 оноос мөнгөн хөрөнгийн төлбөр тооцооны системийг Монголбанкны банк хоорондын системд холбосон. Ингэснээр харилцагчийн хувьцааны мөнгөн хөрөнгийг зөвхөн мөнгө хүссэн өргөдлийг үндэслэн харилцагчийн арилжааны банкны дансанд шилжүүлэх боломж бүрдэж, брокерийн компаниар дамжуулан мөнгөн хөрөнгийг тараах ажиллагааг бүрэн зогсоосон. Өнөөдрийн байдлаар “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК, “ҮЦТХТ” ХХК дээрх системийн оролцогчоор бүртгэгдэж, харилцагчид үйлчилгээг үзүүлж байна. Мөн 2012 онд Хөрөнгийн бирж, Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн бирж хооронд байгуулсан гурван талт програм

хангамж худалдан авах гэрээний дагуу “MIT” системийн арилжаа, тооцоо, хадгаламжийн програм хангамжийг нэвтрүүлсэн. “MIT” систем нэвтрүүлснээр харилцагчийн хувьцааны мөнгөн хөрөнгийн гүйлгээг төлбөр тооцоо гүйцэтгэгч банкаар дамжуулан гүйцэтгүүлэх, харилцагч үнэт цаасны данснаас гадна мөнгөн хөрөнгийн эскроу дансыг нэр бүхий Хаан, Голомт, Хас, Худалдаа хөгжлийн банканд нээлгэх шаардлага тулгарсан. Учир нь “MIT” систем нь Монголбанкны RTGS системд холбогдож чадаагүйгээс харилцагчийн мөнгөн хөрөнгийн гүйлгээ гүйцэтгэх модульгүйгээс шалтгаалан мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэхэд арилжааны банкуудыг татан оролцуулсан байдаг.

2012 оноос харилцагч арилжааны банкинд эскроу дансыг нээлгэх шаардлага бий болсонтой холбоотой гадаадын харилцагч өөрийн биеэр ирж данс нээлгэх, ирэх боломжгүй нөхцөлд оршин суугаа тухайн улсынхаа нотариат, Элчин сайдын яам, Консулын газраас апостиль авч ирүүлэх шаардлага бий болсон. Мөнгөн хөрөнгийн данс нээх ажиллагаанд үүссэн зарим чирэгдэл 2013–2014 онд үнэт цаасны зах зээлд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, хөрөнгө оруулах сонирхлыг бууруулахад багагүй нөлөө үзүүлсэн.

Иймд СЗХ-ны 2014 оны 91 дүгээр тогтоолоор номинал дансаар дамжуулан харилцагчдын мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог гүйцэтгэх боломжийг судлах ажлын хэсэг байгуулагдсан. Үүний үр дүнд Хорооны 2014 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлд номинал данс нээх эзэмших зөвшөөрөл олгох тухай нэмэлт өөрчлөлтийг Хорооны 2014 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 159 дүгээр тогтоолоор оруулсан. Эл нэмэлт өөрчлөлтийн хүрээнд 400.0 сая төгрөгөөс доошгүй хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, төлбөр тооцоо, бүртгэлийн бэк оффисийн програм хангамжтай, эрх авсан мэргэжилтэнтэй компанид номинал дансаар дамжуулан харилцагчид үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгохоор зохицуулсан. Хорооноос дээрх үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгохдоо гадаад харилцагч олонтой, санхүүгийн болон програм хангамжийн чадавх сайтай компаниудад олгох бодлогыг баримталж ирсэн.

2020 оны III улирлын байдлаар Хорооноос мөнгөн хөрөнгийн номинал дансны зөвшөөрлийг 12 компанид олгосон. Энэ

оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс Үнэт цаасны дараа төлбөрт Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийн номинал дансаар дамжуулан харилцагчид мөнгөн хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй компаниудын тоо эрс нэмэгдсэн.

Номинал дансаар дамжуулан харилцагчид данс нээснээр дараах давуу байдал зах зээлд бий болсон. Үүнд:

- Харилцагч банканд өөрийн нэрээр данс нээлгэхгүйгээр ҮЦК-ийн номинал дансаар дамжуулан үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой бөгөөд цаашид брокерийн компани үнэт цаасны номинал дансны эрх авснаар үнэт цаас зээлдэх, зээлдүүлэх үйлчилгээг хүргэх нөхцөл бүрдэх;
- Хурдан шуурхай данс нээлгэж, цаг алдалгүй арилжаанд орох боломжтой. Номинал данс нь тухайн ҮЦК дээр холбогдох журам, шаардлагын дагуу материалыг бүрдүүлж нээгдэх тул харилцагч өөрийн нэр дээр арилжааны банкуудад тухайлсан Төлбөр тооцооны данс нээх үйл ажиллагаатай харьцуулбал шат дамжлага бага, хурдан шуурхай хүргэх;
- Номинал данс нь дансны доод үлдэгдэл байршуулах, данс хөтөлсний шимтгэл зэрэг нэмэлт хураамж шаардагдахгүй; Номинал дансыг нээлгэхтэй холбоотой ямар нэг шимтгэл, хураамж нэмж төлөхгүй байх;
- Төлбөр тооцооны данс нээлгэж тогтмол арилжаанд орох сонирхолгүй боловч эзэмшсэн хувьцаагаа худалдах зорилгоор арилжаанд оролцоход номинал дансыг нээлгэх боломжтой.
- Гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг дотоодын зах зээлд татах, арилжаанд оролцоход хурдан шуурхай үйлчилгээг хүргэх;
- Тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээдүүд цаашид үнэт цаасны номинал данснаас гадна үнэт цаасны номинал данс хөтлөх зөвшөөрөл авсны үндсэн дээр харилцагчийн бүртгэлийг хөтлөх, боловсон хүчин санхүүгийн хувьд бэхжиж, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх, богино арилжааны үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэх;

3. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэх шинэчлэлтэй холбоотойгоор брокерийн компаниуд “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-д гишүүнээр элсэх, номинал данс эзэмших зөвшөөрөл авах сонирхол цаашид нэмэгдэх хандлагатай байна.

Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д дараах өөрчлөлтийг оруулахаар тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэх хэрэгтэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн номинал дансны зөвшөөрөлтэй этгээд нь харилцагчаа таньж мэдэх маягыг боловсруулж, мөрдөх, эцсийн өмчлөгчийг тогтоож мэдээлэх;
- Хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийн шаардлагыг өндөрсгөх, Хороо болон “Монголын үнэт цаасны клирингийн төв” ХХК-д харилцагчийн орлого, зарлага, үлдэгдлийн мэдээллийг сар тутам мэдээлэх;
- Харилцагчийн мөнгөн хөрөнгө, номинал дансны эрхтэй компанийн хөрөнгийг тус тусад нь бүртгэх, балансын гадуурх бүртгэлийн системийг нэвтрүүлж, хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх;
- Номинал дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын үүрэг оролцоог нарийвчлан тодорхойлох.
- Үнэт цаасны номинал дансыг тусгай зөвшөөрөлтэй үнэт цаасны компани хөтлөх зохицуулалтын орчинг бүрдүүлэх, “ҮЦТХТ” ХХК-тай үнэт цаасны дансны мэдээлэл солилцоход шаардлагатай тухайлсан бүртгэлийг хөтлөх программ хангамж, өөрийн хөрөнгө, боловсон хүчинтэй холбоотой зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар зохицуулах.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

“ХУВЬЦААТ КОМПАНИЙН КОМПЛАЙНС, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ” –ЫГ ДҮГНЭЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо, “Нээлттэй нийгэм форум” хамтарч “Хувьцаат компанийн комплайнс, мэдээллийн ил тод байдал” сэдвээр хэлэлцүүлэг зохион явуулж байна. Энэ үеэр СЗХ-ноос компанийн засаглалыг нэвтрүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын шинэчлэл, хувьцаат

компаниудын хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээсэн үүргийн нийцэл, компанийн засаглал, мэдээллийн ил тод байдлын талаар мэдээлэл, бодлого шийдвэрээ танилцууллаа.



Хэлэлцүүлгээр дээрх сэдвийн хүрээнд болон хувьцаат компаниудын нээлттэй, ил тод байдал, үүргийн хэрэгжилт, хурлын зохион байгуулалтад хийсэн хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үнэлгээний тайлан, энэ чиглэлээр хийж буй ажлын талаар хэлэлцлээ. Мөн Хорооноос дээрх чиглэлээр хийж, хэрэгжүүлэх ажлаа зах зээлийн мэргэжлийн оролцогчдоороо хэлэлцүүлж, санал онолыг нь тусгах ажлууд хийхээр шийдвэрлэсэн юм.



Хэлэлцүүлэгт мэргэжлийн холбоод болон хувьцаат компаниудын ТУЗ-ийн гишүүдийн төлөөлөл, зах зээлийн судлаач, мэргэжилтнүүд зэрэг нийт 150 гаруй хүн оролцлоо.

“САНАЛ ХУРААХ КУМУЛЯТИВ АРГЫГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ” –ЫГ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит XVI хуралдаан өнөөдөр /2020.09.09/ хуралдаж даатгал, үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгч болон хадгаламж, зээлийн хоршоотой холбоотой тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичиг бүртгэх тухай болон “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам” –ыг шинэчлэн батлах, Хорооны цахим системүүдийг орчин үеийн технологид нийцүүлэн сайжруулах, цаашид төрийн цахим

системүүдтэй мэдээлэл солилцох хүрээнд хийж хэрэгжүүлэх ажил, авах арга хэмжээний тухай зэрэг нийт 22 асуудлыг хэлэлцлээ.

Энэ удаагийн хуралдаанаар Хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам” –ын хүрээнд 6 компанид, 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам” –ын хүрээнд 9 иргэн, 4 хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл, нэр бүхий нэг иргэнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус, тус олгохоор шийдвэрлэлээ. Мөн нэр бүхий гурван компанийн ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, нэг компанийн тусгай зөвшөөрлийг сэргээхээр шийдвэрлэв.

Харин нэр бүхий нэг компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, нэг компанийн үүсгэн байгуулж буй хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх тухай асуудлыг дахин хэлэлцэхээр хойшлууллаа.

Хуралдаанаар мөн “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам” –ыг шинэчлэн батлахаар шийдвэрлэлээ. Энэхүү журам нь хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчид саналаа нэгтгэн компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид өгөх байдлаар компанийн удирдлагад өөрийн төлөөллийг оруулахыг дэмжсэн зохицуулалт юм. Ингэснээр жижиг хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах явцад хяналт тавих, шаардлагатай мэдээлэл авах боломж бүрдэн эцсийн дүндээ зах зээлийн нээлттэй, ил тод, шударга байдалд эерэгээр нөлөөлнө.

Санхүүгийн зохицуулах хороо төрийн үйлчилгээг хялбаршуулах, иргэд үйлчлүүлэгчдэд шуурхай хүргэх, үйлчилгээний ил тод байдлыг хангах, улмаар төрийн үйлчилгээн дэх хүнд суртлыг арилгах, төвлөрлийг сааруулах зэрэг зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нэлээдгүй ажлыг цахим хэлбэрт шилжүүлсэн. Тухайлбал, тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргахад зориулсан <https://license.frc.mn/> систем, тайлан илгээхэд зориулсан цахим систем гэх мэтчилэн нэрлэж болно. Хуралдаанаар цаашид цахим системүүдийг орчин үеийн технологид нийцүүлэн улам сайжруулж, боловсронгуй болгох, төрийн цахим системүүдтэй мэдээлэл солилцох, кибер аюулгүй байдлыг хангах хүрээнд анхаарч ажиллахыг үүрэг болголоо.

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны III улирлын ээлжит хуралдаан Санхүүгийн зохицуулах хороонд өнөөдөр /2020.09.08/ боллоо. Хуралдаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Монголбанкны

ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирал Х.Бум-Эрдэнэ болон дээрх байгууллагуудын холбогдох албан тушаалтнууд оролцов.



Хуралдаанаар нийт 6 асуудлыг танилцуулсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос “Сэндбокс зохицуулалтын журам”, “Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн төслийг тус, тус танилцуулсан ба дээрх хоёр асуудлыг батлахаар хурлаас хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Сэндбокс зохицуулалтын журам”-ын төсөл нь санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд зохицуулалтын орчинд туршиж, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой. Сүүлийн жилүүдэд бизнесийн салбарт хурдацтай өөрчлөлт өрнөж, хувьсан өөрчлөгдөх үед түүнд тохирсон зохицуулалтыг шууд ашиглан, хэрэгжүүлэхэд хүндрэл үүсдэг. Тэгвэл сэндбокс зохицуулалт нь инновацийн хөгжилд саад учруулалгүйгээр тохирох зохицуулалтыг хурдан хугацаанд боловсруулах боломж олгодоггоороо давуу талтай.

ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХАМТАРЧ АЖИЛЛАХАА ОНЦОЛЛОО



Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь олон улсын түвшинд тулгамдсан асуудал хэвээр байгаа. Манай улсын хувьд ч мөнгө угаах нь гадны орнуудад үйлдэгдсэн гэмт хэргээс олсон орлого, хөрөнгийг нутаг дэвсгэрээрээ нэвтрүүлэх, хадгалах, дамжуулах зэргээр санхүүгийн зах зээлд эрсдэл учруулж болзошгүй билээ. Иймээс Санхүүгийн зохицуулах хорооноос томоохон ажлуудыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлсээр ирсэн. Түүний нэг нь гадаад валютын арилжаа эрхлэгч ББСБ-уудын зохицуулалтын

журмыг Хорооноос баталж, тусгай зөвшөөрөлтэй 156 ББСБ төрийн мэдээллийн “ХУР” системээр харилцагчийг таньж мэдэх, иргэд, байгууллагуудад НӨАТ-ын баримт олгодог байх зохицуулалт юм.

Мөн Хорооны зүгээс мөнгө угаахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, сайжруулах хүрээнд холбогдох байгууллагууд болох Татварын ерөнхий газар, Гааль, татвар санхүүгийн мэдээллийн төвтэй хамтран ажиллаад багагүй хугацаа өнгөрч байна. Энэхүү ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нар уулзаж ярилцлаа. Уулзалтын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “Монгол Улсын төрийн бодлоготой уялдуулан салбарын хөгжил дэвшил тогтвортой байдлыг дэмжсэн санхүүгийн зах зээлийн таатай орчин бүрдүүлэх нь бидний үүрэг. Эрхзүйн зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах, гүнзгийрүүлэх чиглэлд хамтарч ажиллах нь гол зорилго” гэдгийг онцоллоо.

11 КОМПАНИ ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БҮРТГҮҮЛЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо даатгалын үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг сайжруулах зорилгоор нэлээдгүй ажил хийсэн. Түүний нэг нь болох “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”/ <https://www.legalinfo.mn/annex/?lawid=13528> /-ыг батлан мөрдүүлснээр даатгуулагч, зээлдэгчид өөрсдийн сонголтоор даатгалын эрсдэл, даатгагч компани сонгох боломж бүрдсэн. Мөн ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын оролцоог хангаж чадсан. Даатгалын эрсдэл, даатгалын үнэлгээ, хураамж, нөхөн төлбөрийг тодорхой болгож, санхүүгийн эрсдэлээс хамгаалах, даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, даатгуулагчдын эрх ашгийг давхар хамгаалсан.

Даатгуулагч ипотекийн даатгалын бүтээгдэхүүнээ СЗХ-нд бүртгүүлсэн аль ч даатгалын компанид даатгуулах эрхтэй. Харин компани даатгалын гэрээгээр хамгаалах эрсдэл, даатгалын хураамжийн хэмжээ, нөхөн төлбөр олгохгүй нөхцөл зэргээс хамаарч даатгагчаа сонгох, даатгалын зуучлагч банк нь даатгалын гэрээний талаар зөвлөмж өгөх, даатгуулагчийг сонголт хийх боломжоор хангах ёстой.

Энэ оны II улирлын байдлаар “МИГ даатгал” ХХК, “Монгол даатгал” ХК, “Хаан даатгал” ХХК, “Ард даатгал” ХК, “Практикал даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Мандал даатгал” ХХК, “Бодь даатгал” ХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Мөнх даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК зэрэг нийт 11 компани СЗХ-нд бүтээгдэхүүнээ хянуулж, бүртгүүлээд байна.

“САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЦАГ” РАДИО НЭВТРҮҮЛЭГТЭЙ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хороо Монголын үндэсний олон нийтийн радио, телевизтэй хамтран долоо хоног тутмын “Санхүүгийн зах зээлийн цаг” радио нэвтрүүлгийг эхлүүлээд байна.

Энэхүү нэвтрүүлгээр мөнгө угаах санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос явуулж буй бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа болон олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд иргэдэд санхүүгийн мэдлэг, мэдээлэл олгох, олон нийтийг санхүүгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн анхааруулга, сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдэгдэл, мэдээллийг



Монголын үндэсний радиогийн 100.9 сувгаар дамжуулан олон нийтэд хүргэх зорилготой юм.

“Санхүүгийн зах зээлийн цаг” радио нэвтрүүлгийн эхний дугаарт Хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц “Хороо, түүний үйл ажиллагаа” сэдвээр 2020 оны 9 дүгээр сарын 14-ны өдөр оролцож радио сонсогчдод мэдээлэл өглөө.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН УДИРДЛАГУУД СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 2.11-т “Тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын хугацаанд ББСБ-ын удирдлага нь Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна” гэж заасан байдаг бөгөөд уг сургалтыг Санхүүгийн зохицуулах хороо Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоотой хамтран 2020 оны 9 дүгээр сарын 09–11-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Сургалтад 26 ББСБ-ын удирдлагууд хамрагдаж хууль эрх зүйн орчин, хяналт зохицуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, олон улсын туршлага, зээлийн мэдээллийн сан, мөнгө угаахтай тэмцэх зэрэг сэдвээр Санхүүгийн зохицуулах хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын дотоод аудиторчуудын

институт, Цагдаагийн ерөнхий газрын болон нэр бүхий банк бус санхүүгийн байгууллагуудын ажилтан, сургагч багш нар оролцож, мэдлэг, мэдээлэл, туршлагаасаа хуваалцлаа.

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛЛАА



Санхүүгийн зохицуулах хороо мэргэжлийн зарим холбоотой сургалтын чиглэлээр хамтран ажиллах гэрээ үзэглэх арга хэмжээ өнөөдөр боллоо. Арга хэмжээнд Хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Монголын банкуудын холбооны гүйцэтгэх захирал Л.Амар, Монголын даатгалын зуучлагчдын холбооны ерөнхийлөгч Д.Солонго, Монголын даатгалын холбооны Удирдах зөвлөлийн дарга П.Эрдэнэбаатар болон Хорооны зарим газар, нэгжийн дарга нар оролцлоо.

Гэрээг үзэглэснээр Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг хангах зорилгоор даатгалын салбарт ажиллах болон ажиллаж буй нийт ажилтанд зориулсан даатгалын төлөөлөгчийн, зуучлагчийн эрх олгох, мэргэшүүлэх сургалтыг мэргэжлийн түвшинд, чанартай зохион байгуулахын зэрэгцээ Хорооноос сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.



БАЙР СУУРЬ

ШИНЭ ТЕХНОЛОГИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ИДЭВХ, ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛНЭ

Манай улс өөрийн гэсэн “Компанийн засаглалын кодекс”-той. Өнөөдөр түүний хэрэгжилт хэр байна вэ? Хорооноос хэрэгжилтийг засаж, сайжруулах хүрээнд ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Санхүүгийн зохицуулах хороо “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг 2007 онд боловсруулан баталж, хувьцаат компани, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудад мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсөн нь төрийн байгууллагын зүгээс компанийн засаглалын талаарх мэдлэг, мэдээллийг түгээх, уг зарчмуудыг хэрэгжүүлэх суурь болж чадсан. 2014 онд Хороо шинэчлээд дахин баталсан. Хэдийгээр манай улсад компанийн бүтэц, зохион байгуулалтад тулгуурласан бизнесийн үйл ажиллагаа нэвтэрсэн ч хуримтлуулсан туршлага, оролцогч талуудын чадавх харилцан адилгүй. Эрх зүйн болон компанийн өөрийн зохицуулалт хангалтгүйгээс компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага сул, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох нь цөөнгүй. Иймээс компанийн засаглалын зарчмуудад тулгуурлан хувьцаат компани, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нэмэлт шаардлага, шалгуур бүхий эрх зүйн болон зохицуулалтын орчинг бүрдүүлэх шаардлага үүссэн. Ялангуяа бизнес эрхлэгч хувь хүнийг бизнесийн шударга, ёс зүйтэй, тухайн хуулийн этгээд компанийн кодексыг үйл ажиллагаандаа баримталж хэвшүүлэх ажлыг сайжруулах ёстой.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас Их 20 /G20/-ийн орнуудтай хамтарч компанийн засаглалын жишиг зарчмуудыг 2015 онд шинэчилсэн. Үүнтэй холбогдуулан өөрийн орны онцлогт тохирсон, дан ганц нээлттэй хувьцаат компаниуд төдийгүй санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагууд хэрэгжүүлж болохуйц байдлаар “Компанийн засаглалын кодекс”-оо шинэчлэн сайжруулах шаардлагатай. Хороо ч үүний дагуу “Монгол Улсын санхүүгийн зах

зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т санхүүгийн салбарт сайн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох тодорхой зорилтуудыг тусган, хэрэгжүүлж байна. Мөн Хорооны Ажлын албаны бүтцэд компанийн засаглалыг дагнан хариуцсан нэгж буюу “Компанийн засаглал, комплайнсын хэлтэс”-ийг шинээр байгуулсан. Цаашид компанийн засаглал, комплайнсын чиглэлээр зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, олон нийт, зах зээлд оролцогчдод мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх, зөвлөгөө өгөх, зорилтот бүлгүүдэд тохирсон сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулах ажлыг явуулна. Тэр дундаа компанийн засаглалыг сайжруулахад техник, технологийн шийдлийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгоход анхаарч ажиллана.

Компанийн засаглалыг сайжруулахад технологийн шийдлийг ашиглах боломж хэр байна. Ер нь бусад оронд ямар жишиг байдаг бол?

Сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигч олонтой томоохон хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах зардлаа хэмнэх, санал хураах үйл ажиллагааг хялбаршуулах, саналын эрхийг баталгаажуулах зорилгоор мэдээллийн технологийн шийдлийг идэвхтэй ашиглаж эхэлсэн. Тухайлбал, цахим санал хураалт. Энэ шийдэл нь компанийн аливаа асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний эрх ашгаа хамгаалах боломжийг дээшлүүлэх ач холбогдолтой. Том, жижиг ялгаагүй бүх хувьцаа эзэмшигч орон зайнаас үл хамаарч онлайн орчинд компьютер, гар утсаа ашиглан хувьцаа эзэмшигчдийн хуралдаа оролцож, саналаа цахимаар өгөх боломжтой гэсэн үг. Ингэснээр хувьцаа эзэмшигчид, компани ч цаг хугацаа, зардлаа давхар хэмнэнэ. Хувьцаа эзэмшигчдийн анхны цахим хурлыг АНУ-д 2001 онд мэдээлэл технологийн “Inforte Corporation” зохион байгуулсан. Харин 2009 оноос “Intel” компани түүчээлснээр бусад компани

хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахим хэлбэрээр хийх хандлага огцом нэмэгдсэн. Хөрөнгө оруулагчдад мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч “Broadridge Financial Solutions” компанийн мэдээлснээр АНУ-д энэ онд 1000 гаруй компани хувьцаа эзэмшигчдийн цахим хурал хийсэн байна. Ер нь цахим хурлыг англасаксоны системийн орнууд болох АНУ, Их Британи, Канад, Шинэ Зеландад түгээмэл ашигладаг.

Тэгвэл манай хувьцаат компаниуд хурлаа цахим орчинд хэр зохион байгуулж байна вэ?

Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт 199 хувьцаат компани бий. Өнгөрсөн жилүүдэд эдгээр компани хувьцаа эзэмшигчдийг хуралдаа биечлэн оролцуулах эсвэл саналын хуудсаар санал авах замаар ээлжит болон ээлжит бус хурлаа зохион байгуулж оролцоог нь хангаж ирсэн. Харин “COVID-19” цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Засгийн газраас олон нийтийг хамарсан бүхий л арга хэмжээг зогсоосон. Хорооноос ч цахим хэрэгсэл буюу онлайн орчинд зайны технологийг ашиглан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулж зохион байгуулахыг чиглэл болгосноор нэр бүхий 29 компани хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахим хэлбэрээр анх удаа зохион байгуулсан. Ер нь Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцаат компанийн 15 орчим хувь нь энэ онд хувьцаа эзэмшигчдийн хурлаа цахим хэлбэрээр зохион байгуулсан нь компанийн засаглал талаасаа амжилт гэж хэлж болно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал, санал хураалтыг цахим орчинд явуулдаг болох чиглэлд Хорооноос цаашид ямар бодлого баримталж ажиллах бол?

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож компанийн үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл авах, гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх, хяналт тавих, хурлын шийдвэр гаргалтад оролцох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэхэд цахим санал хураалтын технологийг

нэвтрүүлэх нь зайлшгүй шаардлагатай. Учир нь, Нээлттэй нийгэм форумаас Хөрөнгийн биржид бүртгэлтэй “ТОП–20” индексэд багтдаг 20 хувьцаат компанийн 2018, 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулалтад үнэлгээ хийхэд компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоо бага. Ялангуяа гадаадад болон алслагдмал нутагт

оршин суугаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн дүгнэлт гарсан. Иймээс Хороо жижиг хувьцаа эзэмшигчдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, компанийн засаглал, ил тод байдлыг сайжруулах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар зохион байгуулах аргачлал бүхий зохицуулалтын журмыг боловсруулж байна.

Цахим хурлын үеэр хувьцаа эзэмшигч хурлын үйл явцтай шууд танилцах, хэлэлцэж буй асуудлаар санал гаргах, хэлэлцүүлэгт оролцох, саналаа цахимаар өгөх, саналыг баталгаажуулах, нууцлалыг хангах зэрэг асуудлыг дээрх журамд нарийвчлан тусгаж оруулахаар бид ажиллаж байна.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

ДАВХАР БҮРТГЭЛИЙН ЖУРАМД ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР



Санхүүгийн зохицуулах хороо нь 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдөр 758-р тогтоолоор “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компани гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан билээ.

Тус нэмэлт, өөрчлөлтөөр гадаад улсын хөрөнгийн бирж болон Монгол Улсын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй компанийн үнэт цаасыг хооронд нь хөрвүүлэх ажиллагаа ба үнэт цаасны тоо хэмжээний талаарх мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах зорилгоор тухайн компанийн Монгол Улс дахь үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах замаар залруулах боломжийг тус тус бүрдүүлэн, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг бий болгосон.

Өөрөөр хэлбэл, эдгээр зохицуулалтууд нь Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компаниуд хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид арилжаалж, давхар бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу хөгжүүлэн, дотоодын хөрөнгийн зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдын үнэт цаасны үнэ цэнийг хадгалах зэрэгт чухал ач

холбогдолтой юм.

Дээрх журамд орсон нэмэлт, өөрчлөлтөөр дараах харилцааг зохицуулна.

(1) *Монгол Улсын болон гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг хөрвүүлэх ажиллагаа*

- Монгол Улсын болон гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг эзэмшигч нь үнэт цаасаа дотоодын болон гадаадын зах зээл хооронд хөрвүүлж болно.
- Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасаа хөрвүүлэх хүсэлтээ Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хүргүүлнэ.
- Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь хөрвүүлэх ажиллагааг гүйцэтгэж, холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн талаарх тайлан мэдээллийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тухай бүрд мэдэгдэнэ.
- Хөрвүүлсэн үнэт цаасны хэмжээ нь тухайн үнэт цаас гаргагчийн Монгол Улсад бүртгэгдэж арилжаалсан нийт үнэт цаасны 80 хувьд хүрсэн тохиолдолд тухайн үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлээс хасах үндэслэл болно. Ийнхүү Үнэт цаасны бүртгэлээс хасах нөхцөл үүссэн тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага тухайн үнэт цаас гаргагчийн Монгол Улсад бүртгэлтэй, эргэлтэд байгаа үнэт цаасны тоо хэмжээг нэмэгдүүлэх эсэх талаар үнэт цаас гаргагчтай зөвшилцөж болно.
- Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь өөрийн харьяалах улсын

үнэт цаас бүртгэгч байгууллага болон Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулсны үндсэн дээр үнэт цаасаа гадаадын болон дотоодын зах зээл хооронд хөрвөх нөхцөлөөр хангуулах эрхтэй.

(2) *Монгол Улсын болон гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасны бүртгэл, бүрдүүлбэрт орох өөрчлөлттэй холбоотой харилцаа*

- Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь анх бүртгүүлсэн гадаад улсын зах зээлд тухайн төрлийн үнэт цаасыг нэмж гаргах, опцион хэрэгжүүлэх замаар үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох мэдээллийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон төвлөрсөн хадгаламжийн төвд албан бичгээр мэдэгдэх ба үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн мэдэгдлийг үндэслэж, Хорооноос үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна.
- Арилжаа эрхлэх байгууллага нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох мэдээллийг үнэт цаас гаргагчаас албан бичгээр хүлээн авч, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн мэдэгдэлд үндэслэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах үүрэгтэй.
- Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь гадаад улсын зах зээлд тухайн төрлийн үнэт цаасыг нэмж гаргах тохиолдолд урьдчилан Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад албан бичгээр мэдэгдсэн байна.

ФИНТЕК БА РЕГТЕК

ИННОВАЦИЙГ ДЭМЖИХ, ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭРЭГСЛҮҮД

Технологид суурилсан дижитал санхүүгийн үйлчилгээ нь сүүлийн жилүүдэд дэлхийн санхүүгийн салбарыг хурдтайгаар өөрчилж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид болон хэрэглэгчдийн зардлыг бууруулж, алслагдсан нутагт амьдардаг иргэд, санхүүгийн хүртээмжийн гадуур орхигдсон иргэдэд санхүүгийн үйлчилгээг түргэн шуурхай, бага зардлаар хүргэх боломжийг нээж байна.



Санхүүгийн салбарт хурдацтай нэвтэрч буй энэхүү инновацийг дэмжин, зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэхийн сацуу хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, зах зээлийн тогтвортой байдлыг хадгалах нь бодлого гаргагчдад томоохон сорилт болж байна. Финтекийг зохицуулах болон инновацийг дэмжих хэд хэдэн арга хэрэгсэл байдгийг дурдвал:

Зохицуулалтын сэндрокс гэдэг нь шинэ төрлийн бизнесийн үйл ажиллагаанд зохицуулагч байгууллагын хяналтан дор бага хэмжээний цар хүрээг хамран бодит орчинд үйл ажиллагаагаа явуулж, бодитоор турших боломжийг олгосон зохицуулалтын орчныг хэлнэ.

Инновацийн хаб буюу төв нь шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж, инновацид тулгарч буй саад, бэрхшээлд тохирсон арга хэмжээг авдаг зохицуулалтын орчин юм.

Зохицуулалтын технологи буюу регтек нь зохицуулагч байгууллагууд нь технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр цаг хугацаа, мөнгө зэрэг нөөцийг хэмнэх боломжийг олгох технологийн шийдэл, арга хэрэгслүүдийг хэлнэ.

Хурдасгуур нь хөгжиж буй болон шинээр гарч буй старт-ап компаниудад зөвлөгөө, чиглэл өгч техникийн туслалцаа үзүүлдэг хөтөлбөр юм.

	Инновацийн хаб	Зохицуулалтын сэндрокс	Зохицуулалтын технологи
Хууль, эрх зүй, зохицуулалтын орчин	Хууль эрх зүйн хүрээнд төдийлөн хүчин чармайлт шаардахгүй;	Хязгаарлагдмал зохицуулалт тавих, зарим шаардлагыг нь суллах хэрэгцээ гардаг тул зохицуулалтын зүгээс хүчтэй оролцох шаардлага үүсдэг;	Нэмэлт хуулийн зохицуулалт их шаардагдахгүй. Технологийн дэвшлийг нэвтрүүлэх, туршиход бага зэрэг зохицуулалтын шаардлага үүсэж магадгүй;
Шаардагдах чадавх, нөөц	Хаб байгуулах болон үйл ажиллагааг нь явуулахад нэмэлт нөөц шаардагдана;	Сэндрокс зохицуулалт үргэлжлэх бүхий л хугацаанд нэмэлт нөөц шаардагдана;	Технологийн дэвшлийг нэвтрүүлэхэд нэмэлт нөөц шаардагдана;
Зах зээлийн нөхцөл байдал	Зохицуулалт, бодлогын дэмжлэг шаардагдаж эхэлсэн зах зээлд илүү тохиромжтой;	Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд нэмэгдэж байгаа хөгжсөн зах зээлд илүү тохиромжтой;	Зохицуулагч байгууллага нь өөрсдийн үйл ажиллагааг сайжруулах зорилготой зах зээлийн хувьд ашиглагдана;

Инновацийг дэмжих болон финтекийн зохицуулалтын орчинтой холбоотойгоор Дэлхийн банк болон CGAP-ын 2019 онд хамтран зохион байгуулсан Зохицуулалтын сэндроксын судалгааны үр дүнгээс хүргэе. Тус судалгааг 2019 оны 2 дугаар сараас 4 дүгээр сарын хооронд явуулсан ба нийт 28 орны 62 зохицуулалтын байгууллагад хүргүүлсэнээс 31 нь хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын санхүүгийн инновацид тулгардаг гол бэрхшээл нь зохицуулалтын орчин гэж үзсэн ба зохицуулалтын орчинд юу нөлөөлж байна вэ гэдэгт ихэнх нь хүний нөөцийн болон технологийн дутмаг байдал гэж хариулсан байна. Мөн үүнээс гадна санхүүгийн зохицуулагч байгууллагуудын инновацийг дэмжих, хөгжүүлэх сэндрокс, төв зэргийг хэрэгжүүлэхэд нөлөөлсөн


гол шалтгаан нь хурдацтай хөгжиж байгаа финтекийн салбарын зохицуулалт шаардлагатай байсан гэж хариулсан байна.

Инновацийг дэмжих, хөгжүүлэх шаардлага




Эх сурвалж: CGAP-Дэлхийн банк, "Regulatory sandbox global survey"

Инновацийг дэмжих, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал




Эх сурвалж: CGAP-Дэлхийн банк, "Regulatory sandbox global survey"

Хэрэгжүүлсэн арга хэрэгслийн эзлэх хувь



Сэндроксыг хэрэгжүүлж буй улс орнууд



Эх сурвалж: CGAP-Дэлхийн банк, "Regulatory sandbox global survey"

Судалгаанаас харахад оролцогчдын хамгийн ихээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь зохицуулалтын сэндрокс байна.

Дараах зурагт зохицуулалтын сэндроксыг хэрэгжүүлж буй (ногооноор), хэрэгжүүлэхээр төлөвлөж буй (улаанаар) улсуудыг дүрслэн харуулсан байна.

Зохицуулалтын сэндроксыг авч хэрэгжүүлж байгаа улсуудын тоо нь их байгаа хэдий ч тус арга хэрэгслийн хувьд оролцогч болон оролцох хүсэлт илгээсэн байгууллагын тоо бага байгаа нь тавигдах шаардлага өндөр байдагтай холбоотой байх магадлалтай.

Ирүүлсэн болон зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо



Эх сурвалж: CGAP-Дэлхийн банк, "Regulatory sandbox global survey"



СУДЛААЧИЙН ИНДЭР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Мөнхсайханы ЛХАМСҮРЭН¹

ОРШИЛ:

Манай улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойших эхний 15 жилийн хугацаанд эдийн засгийн уналт давамгайлсан хүндхэн он жилүүдийг ардаа үлдээсэн бол дараагийн 15 жилийн хугацаанд эдийн засгийн чөлөөт орчныг бүрдүүлж, зах зээлийг нээлттэй болгон хуулиар хориглоогүй, хийж, бүтээж болох бүхий л бизнесийг бүрэн дэмжиж эдийн засгийн үндэс сууриа бэхжүүлэхэд анхаарсан он жилүүд байлаа гэж хэлж болно. Харин, одоо ийнхүү тавигдсан суурийг зөв тавигдсан эсэхийг нягталж, цаашид хөгжүүлэх чиг хандлага тодорхойлох цаг нэгэнт иржээ.

Ийм ч учраас Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор 'Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030'-ийг баталсан ба уг тогтоолд 'Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих хөгжлийн санхүүжилтийн болон санхүүгийн зах зээлийн зохистой тогтолцоог хөгжүүлнэ. Санхүүгийн зах зээлд банкаас бусад санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, арилжааны банк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийн эзлэх хувийг зохистой түвшинд хүргэнэ'² гэсэн зорилтыг тусгаж, улмаар нэгдүгээр үе шатанд буюу 2016–2020 оны хооронд **санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгож**, санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг 10 хувьд хүргэх зорилтыг тавьсан юм.

Манай улсын хөрөнгийн зах зээл жилээс жилд өссөн үзүүлэлттэй гарч байгааг сүүлийн таван жилийн статистик тоон үзүүлэлтээс тодхон харж болох хэдий ч энэхүү үнэлгээг брокер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны орлого, үнэт цаасны арилжаа, түрээсийн орлого, хүүний орлого болон бусад орлого бүрдүүлж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын сангийн орлого энэхүү үзүүлэлтэд хараахан багтаагүй байна.

Иймд, хөрөнгө оруулалтын сангийн асуудал нь манай улсын хувьд харьцангуй шинэ ойлголт гэж хэлж болох ба хөрөнгө оруулалтын санг зохих ёсоор нь хөгжүүлбэл зөвхөн хөрөнгө эзэмшигчдээ төдийгүй хөрөнгийн зах зээл, цаашлаад улс эх орондоо асар их эдийн болоод эдийн бус хөрөнгийг авч ирэх чадвартай санхүүгийн онцгой механизм тул үүнийг эдийн засаг болон эрх зүйн зохицуулалт талаас нь сайтар судлах хэрэгцээ шаардлага байна гэж судлаачийн зүгээс үзлээ.

СУДЛАГДСАН БАЙДАЛ:

Одоогийн байдлаар хөрөнгө оруулалтын сангийн талаар манай улсын хэмжээнд ойлголт, эдийн засгийн үр өгөөж талаас нь судалсан судалгаа, магистрын зэрэг хамгаалсан ажил, нийтлэл, ярилцлага байгаа боловч эрх зүйн зохицуулалт талаас нь судалсан бүтээл байхгүй байсан болно.

¹ Өмгөөллийн "Кэй И Партнерс" ХХН-ийн ахлах хуульч, МУИС-ийн ХЗС-ийн магистр

² Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030' <http://www.mfa.gov.mn/wp-content/uploads/2015/06/%D0%9C%D0%9E%D0%9D%D0%93%D0%9E%D0%9B-%D0%A3%D0%9B%D0%A1%D0%AB%D0%9D-%D0%A2%D0%9E%D0%93%D0%A2%D0%92%D0%9E%D0%A0%D0%A2%D0%9E%D0%99-%D0%A5%D3%A8%D0%93%D0%96%D0%9B%D0%98%D0%99%D0%9D-%D2%AE%D0%97%D0%AD%D0%9B-%D0%91%D0%90%D0%A0%D0%98%D0%9C%D0%A2%D0%9B%D0%90%D0%9B-2030.pdf>
2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр үзэв. В Т М ДК


ТҮЛХҮҮР ҮГ:

Хөрөнгө оруулалт сан (ХОС), хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК), кастодиан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ОЙЛГОЛТ:

Хэрхэн зардал, эрсдэл багатайгаар өндөр ашиг олох вэ гэдэг асуудал хөрөнгө оруулагч нарын өмнө үеийн үед тулгарсаар ирсэн амин чухал асуултын нэг юм. Энэхүү асуултын нэг хариулт нь хөрөнгө оруулалтын сан гэж хэлж болно. Хөрөнгө оруулалтын сан гэдэг нь хөрөнгө оруулагч тус бүр өөрийн эзэмшлийг хувьцаа/нэгж эрхээр баталгаажуулан хамтдаа үнэт цаасны арилжаа эрхэлж, үүнээсээ ашиг олж байдаг хэсэг бүлэг хөрөнгө оруулагчдын хөрөнгийн нийлүүлэлт юм. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг ерөнхийд нь схемээр дүрсэлбэл:

Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны схем



Эх сурвалж: М.Лхамсүрэн "Хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин, харьцуулсан судалгаа" МУИС-ХЗС магистрын ажил, УБ, 2020

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ МОНГОЛ УЛСАД:

Монгол Улсын хөрөнгө оруулалтын сангийн хууль эрх зүйн орчин 2013 оноос өмнөх буюу хойшх гэж 2 ангилан авч үзэх боломжтой юм. Учир нь одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2013 онд батлагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль" нь хөрөнгө оруулалтын сангийн харилцааг тусгайлан зохицуулсан анхны хууль бөгөөд үүнээс өмнө буюу 1995 оноос 2013 он хүртэлх хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар ерөнхий байдлаар зохицуулж ирсэн байдаг.

А. 2013 оноос өмнөх хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин

1991 онд Хөрөнгийн бирж байгуулагдаж, 1994 онд "Үнэт цаасны тухай хууль" хүчин төгөлдөр болсноор хөрөнгө оруулалтын сан байгуулагдах хууль эрх зүйн боломж бүрдсэн ба уг хуулиар хөрөнгө оруулалтын сан нь үнэт цаасны зах зээлд оролцогч болохыг тодорхойлж, Санхүүгийн

зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн. Мөн хөрөнгө оруулалтын санг хаалттай болон нээлттэй хэлбэртэй байхаар хуульчилж өгсөн байдаг³. Улмаар, улсын үйлдвэрүүдийг хувьчлах зорилгоор тараасан цэнхэр тасалбар дээр үндэслэн хамтын сангууд Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр байгуулагдаж эхлэв. Хамтын санг зохион байгуулах гол зорилго нь иргэдээс итгэмжлэгдсэн хөрөнгөөр үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа явуулах бие даасан санхүүгийн зуучлагч байгууллага болох хөрөнгө оруулалтын сангийн эхлэлийг тавих, иргэдийн хөрөнгийг төвлөрүүлж мэргэжлийн хүнээр удирдуулан ашигтай компанийн хувьцааг худалдан авч улмаар иргэдийн хөрөнгийг өсгөхөд чиглэгдэж байв.

1995 оны 8 дугаар сарын 25-ны өдөр гэхэд Монгол Улсад нийт 29 хамтын сан байгуулагдан, үйл ажиллагаагаа эрхэлж 272 компанийн 3,644,800 ширхэг үнэт цаас арилжсан хэдий ч тухайн үед хөрөнгө оруулалтын сангийн талаарх иргэдийн мэдлэг дутмаг, хөрөнгө оруулалтын санг удирдах мэргэжлийн боловсон хүчин хомс, хууль эрх зүйн орчин хангалтгүй зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалтын сангийн хөгжлийн хурд аажим аажмаар суларсаар 2004 он гэхэд нэг ч хөрөнгө оруулалтын сан үйл ажиллагаагаа хадгалж үлдсэнгүй.

В. 2013 оноос хойш хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин:

Харин 2013 онд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг шинэчлэн баталж, бие даасан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийг баталснаар манай улсад хөрөнгийн зах зээл, цаашлаад хөрөнгө оруулалтын сангийн хөгжилд хөгжлийн шинэ алхам тавигдсан бөгөөд мөн онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан хөрөнгө оруулалтын сангийн орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлсөн⁴ нь хөрөнгө оруулагчдыг татах бас нэгэн тулгуур болсон.

Улмаар, Санхүүгийн зохицуулах хорооноос 2014–2016 онуудад хувийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны журам, түүнд тусгай зөвшөөрөл өгөхтэй холбоотой харилцааг зохицуулах журам, хөрөнгө оруулалтын санд тавигдах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох журам, түүнчлэн, кастодианы үйл ажиллагааны журам, хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох журмуудыг тус тус баталснаар хөрөнгө оруулалтын санг бодитоор үүсгэн байгуулах бүрэн боломж бүрджээ.

2013 онд батлагдсан “Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль”-иар хөрөнгө оруулалтын санг зөвхөн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд 10 хүртэлх жилийн хугацаагаар үүсгэн байгуулахаар тодорхойлж⁵ хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 100,000,000 төгрөг байхаар тогтоосон. Мөн хуулиар хөрөнгө оруулалтын санг хамтын болон хувийн сангийн хэлбэртэй байхаар тусгаж, хамтын сан нь нээлттэй болон хаалттай, хувийн сан нь зөвхөн хаалттай байхаар зохицуулсан. Гэсэн хэдий ч, 2013 оны Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хөрөнгө оруулалтын санг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн бусад хэлбэртэй байж болохоор зохицуулсан нь хуулиудын зохицуулалтын зөрүүг үүсгэж байна. Үүний үр дүнд, дэлхий нийтэд сүүлийн жилүүдэд нэлээдгүй хөгжиж буй биржийн сан буюу exchange traded fund /ETF/-г Монголд үүсгэн байгуулах боломжтой эсэх дээр зохицуулалтын тодорхойгүй байдлыг үүсгэж байгаа юм.

Түүнчлэн, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн нэг сайн зохицуулалт бол хөрөнгө оруулалтын сангийн статусыг маш тодорхой зохицуулсанд оршино. Хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байна. Хөрөнгө оруулалтын сан нь түүний гишүүн хуулийн этгээдийн өмчлөл дэх сангийн нэгж эрхийн хувь, хэмжээнээс үл хамаарч тухайн гишүүн хуулийн этгээдээс хараат бус байх бөгөөд Компанийн тухай хуульд заасан охин болон хараат компани, толгой компанийн хоорондын эрх, үүрэг, хариуцлага хүлээхгүй⁶. ХОС нь тухайн сангийн гишүүний болон тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийн бусдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээхгүй. Мөн ХОС-ийн гишүүн хөрөнгө оруулалтын сангийн бусдын өмнө хүлээсэн үүргийг зөвхөн тухайн хөрөнгө оруулалтын санд оруулсан хөрөнгөөр хариуцах⁷-аар заасан нь хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг ердийн компанийн үйл ажиллагаанаас ялган заагласан оновчтой зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Үүнээс гадна, уг хуулиар хөрөнгө оруулагч нарын өмчлөлийг зөвхөн хувьцаагаар бус нэгж эрхээр бас тодорхойлохоор зохицуулсан. Энэ нь нэг талаас, хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулж буй компанийхаа удирдлагын дотоод үйл ажиллагаанаас ангид байж зөвхөн оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр ашиг хүртэх боломжийг бүрдүүлж буйгаараа давуу талтай.

Хэдийгээр, өнгөрсөн он жилүүдэд хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт ийнхүү бүрэлдэн тогтсон байгаа нь сайшаалтай ч уг зохицуулалт бодит амьдрал дээр тусгалаа олж, хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаа жигдэрсэн гэж үзэхэд бас л учир дутагдалтай хэвээр байна.

Иймд, манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хөрөнгө оруулалтын сангийн харилцааг зохицуулсан дээрх зохицуулалтуудад харьцуулсан шинжилгээ хийх зорилгоор судлаачийн зүгээс хөрөнгө оруулалтын сан өндөр хөгжсөн АНУ болон Саудын Арабын хаант улсын хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалтыг судалж үзлээ.

ГАДААД УЛС ОРНУУДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ:

Саудын Араб улсын хувьд арилжааны банк бүрт өөрийн удирдлага дор хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эрхлэх боломжийг олгодог оронгоо онцлогтой.

Одоогийн байдлаар Саудын Арабын томоохон банкууд бүгд өөрсдийн удирддаг хөрөнгө оруулалтын сантай бөгөөд хөрөнгө оруулалтын санг хөрөнгийн удирдлагын үйлчилгээнийхээ нэг төрөл болгон цахим хуудсандаа байршуулсан байдаг болно. Тухайлбал, Саудын Арабын топ банкуудын нэг болох National Commercial Bank нь NCB Capital гэх хөрөнгө оруулалтын санг удирддаг бөгөөд энэхүү сан нь Саудын Арабын томоохон хөрөнгө оруулалтын санд тооцогддог⁸. Түүнчлэн, Samba банк⁹ болон Alawwal банк¹⁰ нь хөрөнгө оруулалтын сангийн менежерийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хөрөнгө оруулагч нарыг хөрөнгө оруулалтын сантай холбох үүргийг тус тус гүйцэтгэдэг байна. Банк ХОС-ийн үйл ажиллагааг эрхлэхэд банкны зохион байгуулалт сайтай дотоод бүтэц, санхүүгийн зах зээлд мэргэшсэн чадварлаг байдал, хангалттай хөрөнгийн хүрэлцээ зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн.

6 2013 оны Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 7 дугаар зүйл

7 2013 оны Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 8.5, 8.6

8 <https://www.alahil.com/en-us/investments/Pages/Capital-AlAhiil-Funds.aspx> 2020 оны 3 дугаар сарын 12-нд үзэв.

9 <https://dxb.samba.com/en/personal-banking/wealth-management/mutual-funds.aspx> 2020 оны 3 дугаар сарын 12-нд үзэв.

10 <https://www.alawwalinvest.com/en/alawwal-invest/asset-management/mutual-funds> 2020 оны 3 дугаар сарын 12-нд үзэв.

3 Үнэт цаасны тухай хууль <https://www.legalinfo.mn/law/details/7173?lawid=7173>

4 2006 оны Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 18 дугаар зүйл

5 2013 оны Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 14

Саудын Арабын Мөнгөний бодлого хариуцсан агентлаг буюу Saudi Arabian Monetary Agency /SAMA/ нь Саудын Араб дахь банкууд болон тэдгээрийн ХОС-ийн үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавих эрх бүхий байгууллага бөгөөд дээрх захирамжаар банк бүр хөрөнгө оруулалтын сан байгуулахыг үүрэг болгосон.

Арилжааны банкны эрхэлдэг ХОС-ийн зохицуулалтаас дурдвал:

- Банк нь хөрөнгө оруулалтын санг удирдах, тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчийн өмнө хариуцлага хүлээх чиг үүрэг бүхий тусгай хөрөнгө оруулалтын албыг дотооддоо байгуулах бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын алба нь банкны бусад албанаас хөрөнгө санхүү, удирдлагын хувьд тусдаа бие даасан нэгж байна.
- ХОС байгуулсан банк нь хөрөнгө оруулагчдын худалдаж авсан ХОС-ийн нэгж эрхийн тоо, эзэмшигчийн нэр, хаяг зэргийг тусгай бүртгэл хөтлөн бүртгэх үүрэгтэй¹¹.
- Банк нь өөрийн байгуулсан санг маркетингийн оновчтой аргыг сонгон боломжит худалдан авагчдад сангийн талаархи бүрэн бүтэн, сүүлийн үеийн мэдээллийг агуулсан товхимол эсвэл танилцуулга бүхий материалаар хангаж өгөх ёстой.
- Банк нь ХОС байгуулах болон түүний удирдлагыг хэрэгжүүлэх явцад гарсан аливаа зардал, хураамжийг SAMA-гаас зөвшөөрсөн хэмжээнд багтаан хариуцах үүрэгтэй.
- Банкны байгуулсан ХОС нь бие даасан хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд зөвхөн банкны үйлчилгээ гэдэг утгаар хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч болон банкны хөрөнгө оруулалтын алба нарын хооронд гэрээ байгуулагдаж явна гэсэн үг юм.¹²
- Банк нь ХОС-д брокерийн үйлчилгээ болон бусад зуучлагчийн үйлчилгээг гүйцэтгэж болно.
- Банканд анхны хөрөнгө оруулалтаас өөр бусад ямар ч хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын санд хийхийг хүлээн зөвшөөрөхгүй.
- ХОС нь өөрийг нь үүсгэн байгуулсан банкны гаргасан үнэт цаас, хувьцаа, өрийн бичиг зэрэгт хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.
- ХОС нь банкны холбоотой буюу хамааралтай этгээдтэй хэлцэл хийсэн тохиолдолд хэлцлийн үнэ нь зах зээлийн ханшид тулгуурласан байх бөгөөд энэхүү хэлцэл нь ил тод байх ёстой. Сангийн менежер болон кастодиан нь хөрөнгө оруулагчийн ашиг сонирхлыг хамгаалж оролцох үүрэгтэй.¹³

A. АНУ дахь ХОС-ийн эрх зүйн зохицуулалт

Хөрөнгө оруулалтын сангийн хөгжлийн томоохон төв болох АНУ-д хөрөнгө оруулалтын сангийн харилцааг зохицуулсан хэд хэдэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан журмууд байдаг. Тухайлбал, 1933 оны “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” 1934 оны “Үнэт цаасны арилжааны тухай хууль”, 1940 оны “Хөрөнгө оруулалтын компанийн тухай хууль” гэх мэт.

Эдгээрээс 1940 оны “Хөрөнгө оруулалтын компанийн тухай хууль” нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой харилцааг зохицуулж өгсөн гол хууль бөгөөд хөрөнгө оруулалтын сангийн дотоод бүтэц, үйл ажиллагааны хэлбэр, чиг үүрэг, хөрөнгө оруулалтын хэрэгсэл зэргийг зохицуулж өгснөөрөө давуу талтай. Уг хууль нь одоо ч хөрөнгө оруулалтын сангийн харилцааг зохицуулдаг үндсэн баримт бичигт тооцогдох ба түүнд нийцүүлэн баталсан 60 гаруй журам¹⁴ хүчин

¹¹ The Ministerial Decision No 2052, dated 24.7.1413 H., ‘Regulations for investment funds and collective investment schemes circular’, Article 2

¹² The Ministerial Decision No 2052, dated 24.7.1413 H., ‘Regulations for investment funds and collective investment schemes circular’, Article 4.9

¹³ The Ministerial Decision No 2052, dated 24.7.1413 H., ‘Regulations for investment funds and collective investment schemes circular’, Article 4.11

¹⁴ https://www.ecfr.gov/cgi-bin/text-idx?node=17:4.0.1.1.19&rgn=div5#_top 2020 оны 03 сарын 20-нд үзэв

төгөлдөр үйлчилж байна¹⁵.

АНУ-ын хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг нэг бүрчлэн судалж, харьцуулахад бэрхшээлтэй тул гол чухал зохицуулалтуудыг дурдвал¹⁶:

- ХОС нь хууль зүйн статусын хувьд корпораци, бизнесийн буюу хууль ёсны траст, ХХК, ХХН зэрэг олон сонголттойгоор үүсгэн байгуулагддаг. АНУ-ын зарим мужууд нь эдгээрээс өөр хэлбэрээр ч ХОС-г үүсгэн байгуулахыг зөвшөөрдөг байна. ХОС-г тусад нь авч үзэхээсээ илүүтэйгээр хөрөнгө оруулалтын компанид хамааруулан зохицуулсан бөгөөд 1940 оны Хөрөнгө оруулалтын компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан журмуудаар хамтын сан, хөрөнгийн биржийн сан, мөнгөний зах зээлийн сан, индекс сан, хувийн сан, хедж сан зэргийг тусгайлан зохицуулсан байна.
- Түүнчлэн, ХОС-г үйл ажиллагаагаа явуулах дээд хугацааг тогтоож өгдөггүйгээрээ Монгол Улсын зохицуулалтаас ялгаатай байна.
- ХОС нь зохицуулалттай хөрөнгө оруулалтын компанид ангилагдаж байгаа тохиолдолд ХОС-ийн орлогыг орлогын албан татвараас чөлөөлдөг. Харин, ХОС-аас нэгж эрх эзэмшигчидээ хуваарилж буй ногдол ашигт хуульд заасан хувь хэмжээгээр орлогын албан татвар ногдуулдаг байна. Түүнчлэн, АНУ-ын зарим мужуудад хөрөнгө оруулагч нь хувь хүн байгаа тохиолдолд ХОС-аас авах ногдол ашгийг орлогын албан татвараас чөлөөлдөг. 2019 оны байдлаар ийнхүү татвараас чөлөөлдөг 44 муж байна¹⁷.

ДУГНЭЛТ, САНАЛ:

Хөрөнгө оруулалтын сан нь нэг талдаа мөнгөтэй хүмүүсийн мөнгөө өсгөх нэг арга бол нөгөө талдаа санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй этгээдэд хувьцаагаар альтернатив эх үүсвэр татах бас нэг боломж болж өгөх юм.

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалт нь 2013 оны Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох журмуудыг баталснаар харьцангуй зохицуулалт сайтай болсон хэдий ч стратегийн түвшинд хөрөнгө оруулалтын санг дэмжих зайлшгүй хэрэгцээтэй байгаа нь ийнхүү хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчин бүрдээд 5–6 жилийн хугацаа өнгөрсөн ч хөрөнгө оруулалтын сангийн хөгжил өдийг хүртэл хангалттай хөгжөөгүй байгаагаас тодхон харж болно. Иймд, манай улс бусад улс орнуудын сайн туршлагыг харгалзан хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалтыг стратегийн талаас нь сайжруулах шаардлагатай байна.

Үүнтэй холбогдуудан судлаачийн зүгээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Манай улсын хувьд одоогоор арилжааны банк хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эрхлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа. Учир нь, Банкны тухай хуульд 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр арилжааны банк нь охин буюу хараат компанитай байх боломжийг хассан тул одоогийн нөхцөлд банк өөрийн удирдлага дор хөрөнгө оруулалтын сан байгуулах боломжгүй. Түүнчлэн, ХОС-г удирддаг менежментийн үйл ажиллагаа нь хуулиар зөвшөөрсөн банкны эрхлэх үйл ажиллагаанд байхгүй боловч 2018 оноос өмнө банкны тухай хуульд байсан “харилцагчийн даалгавраар түүний нэрийн өмнөөс эрхлэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ”-гээр дамжуулан банк ХОС-г удирдах боломжтой байсан. Гэвч, 2018 онд Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг үйлчилгээг

¹⁵ <https://www.sec.gov/answers/about-lawsshtml.html#invcoact1940> 2020 оны 03 сарын 20-нд үзэв

¹⁶ АНУ-д санхүүгийн салбарт хөрөнгө оруулалтын сангийн төрлүүдээс хамтын хөрөнгө оруулалтын сан тэргүүлэх байр суурьтай хөгжиж буй тул харьцуулалт хийхдээ хамтын хөрөнгө оруулалтын сангийн зохицуулалтыг түүхүү сонгож дурьдсан болно.

¹⁷ <https://www.capitalgroup.com/individual/service-and-support/tax-center/interactive-worksheets/ustreas.htm> 2020 оны 3 дугаар сарын 21-нд үзэв

банкны эрхлэх үйлчилгээнээс хассан тул одоогийн байдлаар банк нь ХОС-ийн хөрөнгийг итгэмжлэн удирдах эрх мөн байхгүй байна. Саудын Араб дах хөрөнгө оруулалтын сан хөгжиж эхэлж буй цаг үед ийнхүү арилжааны банк бүр өөрийн удирддаг хөрөнгө оруулалтын сантай байхыг хуульчилсан нь магадгүй хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын санд итгэж мөнгөө оруулах боломж нөхцөлийг үүсгэж, улмаар хөрөнгө оруулалтын сан хөгжихөд том алхам болсон байхыг үгүйсгэхгүй юм. Иймд, санхүүгийн зах зээл нь арилжааны банканд түшиглэн хөгжиж буй манай улсын хувьд арилжааны банканд тодорхой хяналт, хязгаарлалттайгаар хөрөнгө оруулалтын санг эрхлэх зөвшөөрлийг олгосноор жижиг хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын санд илүү итгэж хөрөнгө оруулалт хийн, улмаар хөрөнгө оруулалтын сангийн найдвартай бат бөх суурийг бий болгох боломжтой гэж үзэж байна.

Хоёрдугаарт, манай улсад 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс «Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга» хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнө хөрөнгө оруулалтын сангийн орлогыг орлогын албан татвараас чөлөөлдөг байсан. Гэсэн хэдий ч, 2019 оны Татварын багц хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх зохицуулалтыг өөрчилж хөрөнгө оруулалтын сангийн орлого нь бусад орлогын нэгэн адил татвар ногдох орлогод хамаарах болсон. Түүнчлэн, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь байнгын хувьцаа болон бусад хөрөнгө оруулалтын хэрэгслийг худалдан авах ажиллагаанд дээр үндэслэгдэх бөгөөд манай улсын одоогийн татварын хууль эрх зүйн хүрээнд уг ажиллагаа бүрт татварын асуудал яригдахаар байна. Энэ хэмжээгээр хөрөнгө оруулалтын сангийн зардал нэмэгдэх бөгөөд ашиг багасахаар байна. Иймд, дөнгөж хөл дээрээ тэнцэн зогсох гэж буй шинэ бизнес болох хөрөнгө оруулалтын санг хөгжүүлэхтэй холбогдуулан судлаачийн зүгээс дараах саналыг гаргаж байна. Үүнд:

- Саудын Арабын жишигт тулгуурласан арилжааны банканд хөрөнгө оруулалтын санг удирдах эрх буюу хөрөнгө итгэмжлэн удирдах эрхийг тодорхой хязгаартайгаар олгох, тухайлбал: хөрөнгө оруулалтын тодорхой хувийг нийтээс татан төвлөрүүлэх гэх мэт
- АНУ-ын жишигт тулгуурлан, жижиг хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд татан оролцуулах, улмаар тэдгээрийн хөрөнгө оруулалтын сангийн талаарх мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэхийн тулд тэдгээрт дэмжлэг үзүүлэх үүднээс хувь хүн хөрөнгө оруулсан тохиолдолд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэг үзүүлэх
- АНУ-ын жишигт тулгуурлан, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй аливаа худалдан авалт, хөрөнгийн шилжүүлгийг татвараас чөлөөлөх
- ХОС-ийн үйл ажиллагааг тогтворжуулах үүднээс нээлттэй, хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг илүү хялбар, уг санг үүсгэн байгуулахад тавигдах шаардлагыг харьцангуй өндөр бусаар тогтоох. Харин, уг санг илүү өргөн цар хүрээнд, илүү өндөр мөнгөн дүнд ажиллах түвшинд хүрсэн тохиолдолд үйл ажиллагааны шаардлагыг илүү нарийн болгох. Ингэснээр жижиг хөрөнгө оруулагч нарыг хөрөнгө оруулалтын сан, цаашлаад хөрөнгийн зах зээлд илүү мэдлэг, туршлагатай болоход тусална.

НОМ ЗҮЙ

Монгол эх сурвалжууд:

А. Эрх зүйн эх сурвалж:

- Үнэт цаасны тухай хууль, 1994 он
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2002 он
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013 он
- Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, 2013 он
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006 он
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2019 он

В. Судалгааны ажлууд, өгүүлэл, нийтлэл:

- Ч.Мөнхтуяа “Хөрөнгө оруулалтын санг хөгжүүлэх боломж” магистрын зэрэг горилсон судалгааны ажил, УБ
- Э.Ууганцэцэг, Д.Энхтуяа “Хөрөнгө оруулалтын сангийн стратегийн сонголт” нийтлэл
- Mongolian mining journal сэтгүүл, Ө.Ганзориг “Хөрөнгө оруулалтын сангаар дамжин триллион төгрөг хөрөнгийн зах руу орох боломжтой” ярилцлага 2013, <http://www.mongolianminingjournal.com/a/52315>

С. Бусад эх сурвалж:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Санхүүгийн Зохицуулах Хороо ‘Санхүүгийн салбарын тойм 2019’ 2 дугаар улирал

Гадаад эх сурвалжууд:

A. Legal sources:

- The Ministerial Decision No 2052, dated 24.7.1413 H., ‘Regulations for investment funds and collective investment schemes circular’,
- Capital Market Law of the Saudi Arabia,
- Kingdom of Saudi Arabia< Capital Market Authority, Investment Fund Regulations,
- **Security act of 1933, U.S.**
- **Security exchange act of 1934, U.S.**
- **Investment company act of 1940, U.S.**
- **General rules and regulations, Part 270 of Investment company act of 1940, U.S.**

B. Research works:

- Paul Roye, Director< Division of Investment Management U.S. Securities&Exchange Commision, “Regulation of Mutual funds in the United States–A Successful
- *Investment Company Institute’s (ICI)2005, ICI Fact Book*
- /Speech of FEFSI General Membership Meeting 2000 <https://www.sec.gov/news/speech/spch402.htm>

C. Other sources:

- <https://www.alahli.com/en-us/investments/Pages/Capital-AIahli-Funds.aspx>
- <https://dxb.samba.com/en/personal-banking/wealth-management/mutual-funds.aspx>
- <https://www.alawwalinvest.com/en/alawwal-invest/asset-management/mutual-funds>
- https://www.ecfr.gov/cgi-bin/text-idx?node=17:4.0.1.1.19&rgn=div5#_top
- <https://www.sec.gov/answers/about-lawshtml.html#invcoact1940>
- <https://www.sec.gov/news/speech/spch402.htm>
- <https://www.capitalgroup.com/individual/service-and-support/tax-center/interactive-worksheets/ustreas.htm>

ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛЫН БИЧИЛ УУРХАЙН НЭГДСЭН ДЭЭВЭР ХОЛБОО

МОНГОЛЫН БИЧИЛ УУРХАЙН
НЭГДСЭН ДЭЭВЭР ХОЛБОО

түүний гишүүнчлэлтэй 89 гишүүн төрийн байгууллагатай, 9500 гаруй гишүүнтэй үндэсний хэмжээний холбоо болон өргөжсөн байна.

АЛСЫН ХАРАА: Бичил уурхайн салбарыг нэгтгэн, тэдний дуу хоолой болж бие даасан тогтвортой, үйл ажиллагаагаа явуулдаг үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүчирхэг Холбоо болох алсын хараатайгаар ажиллаж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО: Гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг тогтвортой ажлын байртай, орлоготой, байгаль орчны болон нийгмийн хариуцлагатай бичил уурхайчин, бизнес эрхлэгч болгон төлөвшүүлэх, улмаар амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- Бичил уурхайн бодлого эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажилласан
- Хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр ХЭҮК-той хамтран ажилласан.
- Хууль бус ашигт малтмал олборлогч нарыг албажуулж, хуулийн хүрээнд ажиллахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр 32,000 хүнд сургалт, мэдээлэл хийж ажилласан
- 540 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн
- ХАБЭА-н хөтөлбөрийн хүрээнд нийт 6500 орчим хүнд ХАБЭА-н сургалт зохион байгуулсан
- Бичил уурхайн салбарт ажиллаж буй өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр Канад сантай хамтран ажилласан
- Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалыг хоргүй технологи нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байна.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ



ТАНИЛЦУУЛГА: Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо (МБУНДХ) нь 2013 онд бичил уурхай эрхлэгчдийн эрхийг хамгаалах зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллага юм. Одоогийн байдлаар 13 аймгийн холбоо

- Хүүхдийн гэр цэцэрлэгийн төсөл хэрэгжүүлсэн
- Хүүхэд хамгаалал, Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхийн мэдлэг олгох, хорт бодисын хор аюулыг таниулах чиглэлээр Эх-үрс хөгжлийн хөтөч хүүхэд эмэгтэйчүүдийн аяныг 11 аймгийн 12 суманд 4035 хүнийг хамруулан зохион байгуулсан.

ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА:

МБУНДХ нь байгуулагдсан цагаасаа Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал газрын тосны газар, Байгаль орчин аялал жуулчлалын яам, ОБЕГ-ын харьяа Уул уурхайн аврах анги, аймаг, сумдын засаг даргын тамгын газар, Экологийн цагдаагийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Нээлттэй нийгэм форум, Хүний эрхийн үндэсний комисс гэх мэт төрийн болон төрийн бус байгууллага, Швейцарын хөгжлийн агентлагын Тогтвортой бичил уурхай төсөл, Канадын элчин сайдын яам, Америкийн нэгдсэн улсын элчин сайдын яам, Трафигура сан, Дэлхийн банк, Планет голд төсөл, Олон улсын алтны бичил уурхайн зөвлөл, Олон улсын хариуцлагатай уул уурхайн холбоо зэрэг олон улсын байгууллагуудтай өргөн хүрээнд түншилж хамтран ажиллаж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООТой ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

МБУНДХ нь алтны гарал үүсэл, алтны арилжаа эрхлэгч нарын үйл ажиллагааг албажуулах замаар алтны нийлүүлэлтийн сүлжээг албажуулах чиглэлээр 2017 оноос хойш идэвхтэй ажиллаж байгаа бөгөөд энэ талаар Олон улсын эдийн засаг хамтын ажиллагааны байгууллага (OECD), Олон улсын засгийн газар хоорондын форум (IGF) зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан цөөнгүй олон улсын хурал уулзалтуудад оролцож илтгэл мэдээлэл хийсэн.

2020 оноос эхлэн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын дагуу үнэт металлын арилжаа эрхлэгч нарт тусгай зөвшөөрөл олгохтой холбоотойгоор мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургах, чадавхжуулах зэргээр хамтран ажиллаж байна.

Банк санхүүгийн академиас зохион байгуулсан Сургагч багш бэлтгэх сургалтаар 6 сургагч багш бэлтгэгдсэн бөгөөд багш нараараа дамжуулан үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн тусгай зөвшөөрөл авсан арилжаа эрхлэгч нарт хүрч ажиллах, сургалт зохион байгуулах боломжтой болсон.

ЦААШИД: Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нарын мэргэжлийн холбоодтой хамтран тус салбарын хөгжил, бодлого эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гадаад дотоод харилцааг өргөжүүлэх чиглэлээр ажиллахаар төлөвлөж байна.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

“ХУВЬЦАА ГЭЖ ЮУ ВЭ?”

Хувьцаа гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хэлнэ.



Хөрөнгө оруулагч өөрийн эзэмшлийн хувьцааг арилжих олон шалтгаан байдаг. Жишээлбэл, тухайн хөрөнгө оруулагч хувьцааны авсан үнэ болон зарах ханшийн зөрүүнээс ашиг олох буюу хөрөнгийн өсөлтөөс ашиг олох зорилготой байж болно. Зарим хөрөнгө оруулагчид хувьцааны орлогын өгөөж буюу хөрөнгө оруулсан хувьцааны ногдол ашгийн өгөөж хүртэхийг зорьж байдаг. Мөн хөрөнгө оруулагчид маржин арилжаа буюу хувьцаагаа өндөр үнээр зарж, бага үнээр буцааж авах байдлаар ашиг олохыг зорьдог байхад зарим нь хувьцаа эзэмшсэнээр хүртдэг дэлгүүрийн купон зэрэг элдэв дагалдах урамшуулал, бэлэг хүлээн авах сонирхлоор хувьцааны арилжаанд оролцдог байна.

Хувьцаа нь гол төлөв хөрвөх чадвартай буюу тухайн хувьцааг эргүүлээд зах зээлд худалдахад хялбар байдаг. Хөрөнгө оруулагчид хувьцааны арилжааг хялбар хэрэгжүүлэх зорилгоор зах зээлээс харилцагч талууд болох худалдагч эсхүл худалдан авагч нарыг хайж байдаг бөгөөд нөгөө талд, компаниуд хувьцаа гарган урт хугацааны хөрөнгөө өсгөхийг зорьдог. Тиймээс хувьцааны арилжаа явагддаг зах зээл буюу “хоёрдогч зах зээл” нь хөрөнгө оруулагчийн хувьд ч, хувьцаа гаргаж буй компанийн хувьд ч эдгээр хэрэгцээг нь хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Хоёрдогч зах зээл нь хувьцааг зах зээл дээр шударга үнээр эргэлдэх боломжийг олгохоос гадна хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг төрүүлдэг бол компаниудын хувьд нэмж хөрөнгө оруулалт татах тааламжтай нөхцөлийг бүрдүүлж өгдөг байна.

ХУВЬЦААНЫ ТӨРЛҮҮД

Үнэт цаас гаргагч компани үндсэн хоёр төрлийн хувьцааг санал болгодог: (1) **энгийн хувьцаа** /common stock/ болон (2) **давуу эрхийн хувьцаа** /preferred stock/ юм.

Энгийн хувьцаа эзэмшигч ихэнхдээ тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох болон ногдол ашиг авах эрхтэй байдаг.

Харин давуу эрхийн хувьцаа эзэмшигчид саналын эрхгүй боловч тогтмол хэмжээний ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигчээс тэргүүн ээлжинд авах эрхтэй байдаг.

Компани Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус хугацаанд хуримтлагдсан ашгаас ногдол ашиг тараах эсэх асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд зарим тохиолдолд хуримтлагдсан ашгаа компанийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд ашиглаж, ногдол ашиг тараахгүй байх шийдвэрийг гаргаж болдог.

Харин давуу эрхийн хувьцааны хувьд компани алдагдалтай ажиллаж байсан ч ногдол ашгийг хуваарилах ёстой байдаг. Бүх компани энгийн хувьцаа гаргах үүргийг хуулиар хүлээдэг ба харин давуу эрхийн хувьцааг өөрийн сонголтоор гаргадаг байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХҮҮД

Хувьцаа нь хэд, хэдэн эрхийг агуулж байдаг бөгөөд хамгийн түгээмэл хэвшсэн эрхүүд нь дараах байдалтай байдаг:

1. Санал өгөх эрх;

Ихэвчлэн хувьцаа эзэмшигч бүр саналын эрхтэй байдаг. Хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож компанийн ТУЗ-д хэн сонгогдох (эсхүл хасагдах), нягтлан бодох бүртгэлийн зөвлөх, компанийн аудиторроор хэнийг сонгох болон компанийн үйл ажиллагааг эхлүүлэх, менежментийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлт хийх, үнэт цаас гаргах эсэх гэх мэт компанийн бодлоготой холбоотой чухал шийдвэрүүдэд санал өгөх эрхтэй.

2. Хуримтлагдсан ашгаас ногдол ашиг хүртэх, төлөхийг шаардах эрх;

Төлбөр эсвэл ногдол ашиг авах нь зөвхөн тодорхой нэг хувьцаа эзэмшигчид ашигтай байдаг тул уг эрхийг “хувийн эрх” гэж нэрлэх

нь бий. Хувьцаа эзэмшигчид ТУЗ-өөс тогтоосон ногдол ашиг олгохыг шаардах эрхтэй.

3. Компани татан буугдах үед үлдэгдэл хөрөнгө хүртэх эрх;

Хэрэв компанийг татан буулгах шийдвэр гарсан бол компанийн хөрөнгөнөөс хамгийн түрүүнд бонд эзэмшигчдийн өр төлбөрийг, дараа нь давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд, хамгийн сүүлд энгийн хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө хуваарилдаг.

4. Тэргүүн ээлжинд хувьцааны арилжаанд оролцох эрх;

Компани нэмж хувьцаа гаргахаар шийдсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчид тухайн үеийн эзэмшлийн хувиа хэвээр байлгахын тулд нэмэлт хувьцаанаас нийтэд санал болгохоос өмнө худалдан авах эрхтэй байдаг. Хувьцаа эзэмшигч нь эзэмшлийн нэг ширхэг хувьцаа тутамд нэг эрхтэй болдог. Тэргүүн ээлжинд худалдан авах захиалгад шинээр гарч буй нэг ширхэг хувьцааг эзэмшихэд хэчнээн эрх шаардагдах, худалдан авах үнэ, эрхийн хүчинтэй хугацаа болон нэмэлтээр шинэ хувьцааг зах зээлд санал болгох өдөр зэргийг тодорхой дурдсан байдаг.

5. Компаниас хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх;


Хувьцааг нь эзэмшиж байгаа компани дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулж эсхүл шинэчлэн найруулж тэр нь таны эрх ашгийг хөндсөн эсхүл санал хураалтад нь оролцоогүй бол хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг компаниас шаардах эрхтэй. Компани хувьцаагаа эргүүлэн худалдан авахдаа тухайн үеийн зах зээлийн үнийг баримтална.

6. Мэдээлэл авах эрх.

Хувьцаа эзэмшигч нь дараах мэдээллийг компаниас авч танилцах эрхтэй юм.

Хувьцаа эзэмшигч нь хувьцааг нь эзэмшиж байгаа компанийнхаа жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай танилцах, энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн бусад энгийн хувьцаа эзэмшигчдийн нэр, оршин суугаа хаяг, эзэмшлийн хувьцааны тоо зэрэг мэдээллүүдтэй танилцах эрхтэй байдаг.

ХУВЬЦААНЫ ЭРСДЭЛ



Хувьцаанд хөрөнгө оруулах нь банканд мөнгө хадгалуулах эсхүл бонд худалдаж авахаас илүү ашигтай боловч тэр хэрээрээ *эрсдэл өндөртэй*.



Аливаа компанийн хувьцааны ханш үргэлж тогтмол байдаггүй бөгөөд гадаад, дотоод хүчин зүйлээс болж хэлбэлзэж байдаг. Өндөр үнэтэй худалдаж авсан хувьцаа ханшийн уналтад орох

эсхүл хувьцааг нь худалдан авсан компани дампуурах тохиолдол байдаг.

Танд гэнэт мөнгө хэрэг болоод хувьцаагаа зарах хэрэгцээ гарсан үед хувьцааны ханш буурах магадлалтай.




ХЭРЭГЛЭГЧ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 133 өргөдөл, гомдол ирсэн байна.



Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбартай холбоотой өргөдлийн тоо болон ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоо өссөн байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 133 өргөдөл, гомдол ирснээс:

Хүснэгт. Өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	121
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	10
Хугацааг нь сунган хянагдаж буй	2

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоног уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэл хийх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 23 иргэн Хорооны цахим хаягаар хандсан байх ба үүнээс даатгалын чиглэлээр 1, үнэт цаасны чиглэлээр 9, мөн банк бус санхүүгийн байгууллагатай холбоотой 8, бусад 5 /ломбард, ТМАТ автомат машин, Анод банк гэх мэт/ асуудалд тухай бүр бүртгэл хөтлөн хариу өгч байна.

Дүрслэл. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа (хоногоор)



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ НЬ

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 2 дугаар зүйлийн 2.1.5–д зааснаар тус Хороонд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох үндсэн зорилтыг ханган ажиллах бүрэн эрхийг олгосон байдаг.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд компанийн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа хэвшил болговоос компанийн тогтвортой хөгжил, хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдэх учиртай. Энэ хүрээнд “Компанийн засаглалын кодекс” буюу компанийн удирдлага, зохион байгуулалтын зарчмуудад сайн засаглалын практикийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай байсан тул тус Хорооноос “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг боловсруулж, 2007 оны 12 дугаар сарын 26–ны өдөр батлан Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компани, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагад мөрдлөг болгон ажиллахыг зөвлөсөн нь төрийн байгууллагын зүгээс компанийн засаглалын талаарх мэдлэг мэдээллийг түгээх, уг зарчмуудыг хэрэгжүүлэх шаардлагыг тавих суурь болсон. Улмаар Хорооны 2014 оны 5 дугаар сарын 07–ны өдрийн 162 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн баталсан байдаг. Энэхүү кодексыг олон улсын байгууллагуудын зөвлөмж, өөрийн орны онцлог, бодит нөхцөл байдал, эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх эерэг нөлөө зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр боловсруулсан. Тэгэхдээ хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг нээлттэй хувьцаат компанид тусгайлан боловсруулсан бөгөөд хязгаарлагдмал хариуцлагатай компани болон бусад хуулийн этгээдийн тухайд өөр өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой юм.

Манай улсад компанийн бүтэц, зохион байгуулалтад тулгуурласан бизнесийн үйл ажиллагаа хөгжсөн боловч хуримтлуулсан туршлага хомс, оролцогч талуудын чадавх харилцан адилгүй, эрх зүйн болон компанийн өөрийн зохицуулалт хангалтгүй байгаагаас компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/, гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага сул, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох нь цөөнгүй байдаг. Мөн өнөөгийн нөхцөлд компанийн засаглалын зарчмуудад тулгуурлан хувьцаат компани болон санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нэмэлт шаардлага, шалгуурыг бий болгох эрх зүйн болон зохицуулалтын орчинг сайжруулах шаардлага үүссэн. Ялангуяа бизнес эрхлэгч хувь хүнийг бизнесийн шударга, ёс зүйтэй болгосноор тухайн хуулийн этгээд компанийн кодексыг үйл ажиллагаандаа баримталж хэвшүүлдэг болгох явдлыг тоон болон чанарын үзүүлэлтээр нь мэдэгдэхүйц сайжруулан ахиц гаргах шаардлагатай.

Нөгөө талаас Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)–аас Их хорийн орнуудтай хамтарч компанийн засаглалын жишиг зарчмуудыг шинэчилсэн нь түүнийг дэлхийн түвшинд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн бөгөөд үүнд тулгуурлан, өөрийн орны онцлогт тохирсон, дан ганц нээлттэй хувьцаат компаниуд гэлтгүй санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагууд хэрэгжүүлж болохуйц “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэх шаардлага үүсээд байна.



Энэ хүрээнд Хорооноос “Монгол улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т санхүүгийн салбарт сайн засаглалыг хөгжүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчны тогтолцоог боловсронгуй болгох зорилтуудыг тусгуулсан ба төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Мөн “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилтийг идэвхжүүлэх, шинэчлэн сайжруулах зорилгоор Хороо өөрийн бүтэцдээ 2020 оноос Компанийн засаглал, комплайнсын хэлтсийг шинээр бий болгож, компаниудад олон улсын тэргүүн туршлагыг нутагшуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, компанийн засаглалыг үнэлэх, олон нийтэд болон зах зээлд оролцогчдод мэдлэг, мэдээлэл түгээх, сургалт, семинар, хэлэлцүүлгийг зохион байгуулах, гарын авлага, тараах материалыг бэлтгэх, заавар, зөвлөмж, аргачлалыг боловсруулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.

Компанийн засаглалыг сайжруулах чиг үүргийг хариуцсан нэгж байгуулагдсанаар энэ чиглэлд илүү бодитой ажлуудыг шат дараатайгаар хийх боломж үүссэн гэж харж байна. Компанийн засаглал, комплайнсын чиглэлээр зохицуулалтын орчинг боловсронгуй болгох, олон нийт болон зах зээлд оролцогчдод мэдээ, мэдээлэл тогтмол хүргэх, зорилтот бүлгүүдэд тохирсон сургалтыг зохион байгуулах, зөвлөгөө өгөх, гарын авлага боловсруулах зэрэг ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна. Ялангуяа Хорооны зохицуулалтад хамаарах санхүүгийн байгууллагуудын компанийн засаглалын түвшинг тогтоож, үнэлэн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох замаар “Компанийн засаглалын кодекс”-ыг шинэчлэн боловсруулахад голчлон анхаарч ажиллаж байна.

Мэдээж энэ зорилтуудыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлт маш чухал. Иймд бид зохицуулалттай салбаруудын мэргэжлийн холбоод, өөрийгөө зохицуулах болон холбогдох төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд нийт
526 зохицуулалттай этгээд,
хувьцаат компани үйл ажиллагаа
явуулж байна.

Арилжаа эрхлэх 2	Тооцооны 2	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн 1
ХОМК 23	Арилжаа эрхлэгчдийн холбоо 1	Кастодиан 3
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк 2	Хөрөнгө итгэмжлэн удирдах 5	ХК 304
ҮЦК* 53	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх 1	ХАА түүхий эдийн брокер 14
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх 59	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх 24	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх 33

*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.



Үнэт цаасны зах зээлийн арилжаа

- 2020 оны 2 дугаар улиралд нийт 29.1 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 67.8 хувиар буурсан.
- Нийт арилжааны 2 хувийг ЗГҮЦ, 17.2 хувийг компанийн бонд, 80.8 хувийг хувьцаа тус тус эзэлж байна

Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,576.3 нэгжээр буюу 22.0 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,680.6 нэгжээр буюу 17.2 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 635.9 нэгжээр буюу 7.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ТОП
20

16,208.9

MSE
А

8,062.5

MSE
Б

7,480.9




ХААБ-ээр нийт 162.1 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 361 тэрбум төгрөгөөр буюу 69.0 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд зөвхөн 4 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.




ХАА-н биржийн MAPIX индекс

ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу MAPIX 2020 оны 2 дугаар улирлын байдлаар 918,691.4 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54,687.0 нэгжээр өссөн.





1.2 ДААТГАЛЫН САЛБАР




ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 2 дугаар улиралд даатгалын гүнзгийрэлт 0.57 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.07 хувиар буурсан байна.




* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- 2020 оны 2 дугаар улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 хувиар өсөж 359.2 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад өмнөх оны мөн үеэс 8 хувиар өсөж 293.9 тэрбум төгрөгт хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.1 хувиар буурч, 55.7 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор давхар даатгалын хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 5.2 хувиар өсөж, 9.6 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 2 дугаар улиралд нийт 94.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 94.1 тэрбум төгрөг буюу 99.2 хувь, урт хугацааны даатгалын компани 0.7 тэрбум төгрөг буюу 0.8 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 24.8 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 1.6 тэрбум төгрөг буюу 6.3 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 2 дугаар улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.5 хувиар буурчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР



- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 2 дугаар улиралд 27.7 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 67.3 хувиар өсөж 1.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.



1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

- 2020 оны 2 дугаар улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 542 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 77 буюу 14.2 хувь нь орон нутагт, 465 буюу 85.8 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.7 хувь нь гадаадын хөрөнгө оруулалтаар, 94.3 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 2 дугаар улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 329.0 тэрбум төгрөгөөр буюу 21.5 хувиар өсчээ.






НИЙТ ЗЭЭЛ

2020 оны 2 дугаар улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар буюу 210.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Зээлийн хүү: 2020 оны 2 дугаар улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.9 хувьд хүрч буурлаа.

2020 оны 2 дугаар улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.6 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.4 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.




97.6%



1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД

- 2020 оны 2 дугаар улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 256-д хүрч өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар буурлаа.
- ХЗХ-дын гишүүдийн тоо 2019 оны 2 дугаар улиралд 67,434 байсан бол 2020 оны 2 дугаар улиралд 7.1 хувиар өсөж 72,230-т хүрчээ.



АЖИЛЛАГСАД

770

ХЗХ-дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.1 хувь нь эмэгтэй

НИЙТ ГИШҮҮДИЙН

36,575


ЗЭЭЛДЭГЧ

35,385

**ХАДГАЛАМЖ
ЭЗЭМШИГЧ**

НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ


- 2020 оны 2 дугаар улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 11.4 хувиар өсөж 234.4 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 8.1 пунктээр буурчээ.



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ


Хөрөнгийн зах зээл

33Ү /их наяд төгрөг/




Дунджаар 2.59 их наяд төгрөгт хүрсэн.

ТОП-20 индекс




16,718.8 буюу өмнөх сарын дунджаас 268.3 индексээр өссөн.

MSE A индекс



8,146.3 буюу өмнөх сарын дунджаас 182.2 индексээр нэмэгдсэн.

MSE Б индекс



7,390.4 буюу өмнөх сарын дунджаас 68 индексээр буурсан.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, www.mse.mn

Бүртгэлтэй үнэт цаасны тоо ширхэг

15,138,678,787

Хоёрдогч хувьцааны арилжааны үнийн дүн

/тэрбум төгрөг/



Нийт хийгдсэн хэлцлийн тоо

БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Биелсэн хэлцэл

165

Богцын нийт хэмжээ

166,792

Богцын нийт үнийн дүн

100.6


/тэрбум төгрөг/

Нэгж богцын дундаж үнэ

609,9


Эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж, www.mse.mn

		2020.07 сар	2020.08 сар	Өөрчлөлт
Зэс	А зэрэглэлийн, Лондонгийн металлын бирж, тонн тутмын ам.доллар	6,372.5	6,508.4	2.1%
Алт	Лондонгийн гулдмайн зах зээлийн холбоо, 3 цагийн тогтмол ханш, унц тутмын ам.доллар	1,843.3	1,968.0	6.8%
Мөнгө	Лондонгийн гулдмайн зах зээлийн холбоо, унц тутмын ам.доллар	20.4	26.9	31.9%




Эх сурвалж: www.data.imf.org

	2020.07 сар	2020.08 сар	Өөрчлөлт
Молибден	15,964.3	16,699.5	4.6%
Никель	13,402.3	14,575.8	8.8%
Цагаан тугалга	17,469.9	17,660.4	1.1%



Эх сурвалж: www.data.imf.org

	2020.07 сар	2020.08 сар	Өөрчлөлт
Хөнгөн цагаан	1,643.8	1,738.6	5.8%
Төмрийн хүдэр	108.0	120.1	11.2%
Хар тугалга	10.9%	1,936.3	6.5%
Цайр	2,177.2	2,413.9	10.9%




Эх сурвалж: www.data.imf.org

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр

S&P 500 /^GSPC/


3,281.06 -38.41 (-1.16%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


23,360.30 +40.90 (+0.18%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


5,804.29 -202.76 (-3.38%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Dubai Financial Market General Index DFMGI:IND

2,270.05 -50.23 /-2.16%/



Эх сурвалж: www.Bloomberg.com





📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

☎ +976-51-264444

✉ press@frc.mn

🌐 www.frc.mn

📘 Санхүүгийн зохицуулах хороо

🐦 @FRC_of_Mongolia